



## Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: МУИС-ИЙН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: “ЭРХ ЗҮЙ”

Индекс: D42101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Эрдэнэбаатар

Гишүүд:

С.Энхбаяр

Г.Туяа

2022.06

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

## Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
МУИС	Монгол Улсын их сургууль
ХЗС	Хууль зүйн сургууль

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр</b> /Монгол, Англи/	Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургууль National University of Mongolia	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр</b> /Монгол, Англи/	Эрх зүй Law	
<b>Индекс</b>	D042101	
<b>Шинжээчид</b>	<p>Ахлагч: Д.Эрдэнэбаатар</p> <p>Дотоод хэргийн их сургуулийн багшийн хөгжлийн төвийн сургалтын менежер, доктор (Ph.D), дэд профессор</p> <p>Гишүүд:</p> <p>С.Энхбаяр</p> <p>Санхүү, эдийн засгийн их сургуулийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор</p> <p>Г.Туяа Их засаг олон улсын их сургуулийн сургалт эрхэлсэн захирал, доктор (Ph.D), дэд профессор</p>	
<b>Зохицуулагч</b>	Ц.Цацрал Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022-06-06	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №А/134
	2022-06-06	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022-06-13	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022-06-16/17	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022-06-30	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022-07-04	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
		Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

**Зорилго:** Бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачилгатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино<sup>1</sup>.

### Хөтөлбөрийн хүрэх үр дүнг PLOs (Program Learning Outcomes)

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай уялдуулан оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлагын хүрээнд нийт 29 үр дүнг тодорхойлсон. Эдгээрийг багцалж хэлбэл, Эрх зүй мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөр нь төгсөгчдийг цаашид ахисан түвшинд суралцах, хууль зүйн шинжлэх ухааны тодорхой салбараар судалгаа хийж, диплом, диссертац хамгаалах онол, арга зүйн мэдлэг, чадвартай болохоос гадна мэргэжлийн дагуу суурь болон тухайлсан бэлтгэл бүхий мэргэжлийн үйл ажиллагааны бэлтгэлтэй байж, бүх шатны шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, өмгөөлөл, төрийн болон гадаад, дотоодын төрийн бус байгууллагад эрх зүйч, хуульч, мэргэжилтнээр ажиллах, бизнесийн байгууллагад хуулийн зөвлөх, хуулийн болон гэрээний мэргэжилтнээр ажиллах, хувийн сэтгэл хөдлөлд автагдахгүйгээр сэтгэн бодох чадвар, тодорхой нөхцөл байдалд хууль зүйн дүгнэлт, гаргалгаа хийх чадвар, хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд төрөл бүрийн салбарт эрх зүйн шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэх, тайлбарлах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, мэргэжлийн үнэт чанарыг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

### Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

Хөтөлбөрийн зорилтыг Монгол Улсын их сургуулийн “Шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу Либерал арт уламжлалд суурилсан хөтөлбөр байх” эрхэм зорилгын хүрээнд зорилт 1, 2, “Байгалийн ухаан, эдийн засаг, нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт, судалгааны ажлыг тогтвортой эрхэлж, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх эрхэм зорилготой академик буюу эрдмийн байгууллага болох” зорилгын хүрээнд зорилт 3, 4, 5-ыг тус тус дэвшүүлсэн байна<sup>2</sup>. Үүнд:

Зорилт 1. Нийгэм, зах зээл эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт, шинжлэх ухаан, техник технологийн шинэчлэлд сургалтын төлөвлөгөөний агуулга, багтаамжийг нийцүүлэн уян хатан хандаж, сургуулийн багш нарын бүрэлдэхүүнийг эрдмийн зэрэг цол хамгаалсан чадвартай боловсон хүчнээр нэмэгдүүлж, сургалтын чанарт ахиц гаргах.

Зорилт 2. Төрийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн зэрэг төгсөгчдөд ажил олгож буй болзол, шаардлагад нийцүүлэн сургалтын чанарт ахиц гаргах.

Зорилт 3. Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг багшлах үйл ажиллагаатай нь энэ тэнцүү тавьж үр дүнг тооцож, эрдэм шинжилгээ судалгааны ажлын цар хүрээг өргөтгөх.

Зорилт 4. Нийгэмд үйлчлэх хүрээг өргөтгөж, гадаад, дотоодын байгууллагуудаас санхүүгийн дэмжлэг авч, сургалт-эрдэм шинжилгээний ажлын чанарыг сайжруулахад ашиглах, сургалтын багц материал бүрдүүлэхэд чанарын ахиц гаргах.

<sup>1</sup> Сургалтын хөтөлбөрийн 10 дахь тал.

<sup>2</sup> Мөн тэнд.

Зорилт 5. Сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, багш нар мэргэжлийн болон гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлж гадаад, дотоодод сургалтад хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд ажиллах.

### Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

#### Мэдлэг

- М.1** Одоо үйлчилж буй хууль тогтоомжийн талаар мэдлэгийг түүхэн, улс төр, эдийн засаг, эрх зүйн философийн үүднээс судлуулж онолын суурь мэдлэгийг оюутанд эзэмшүүлэх
- М.2** Хүний эрх, эрх чөлөөний талаарх ойлголт, мэдлэгийг эзэмшүүлэх
- М.3** Иргэний нийгэм, эдийн засаг, соёлын системтэй холбоо бүхий эрх зүйн тухай мэдлэгийг эзэмшүүлэх
- М.4** Орчин үеийн эрх зүйн тогтолцооны үндсэн хэлбэрүүдийн мэдлэг, ойлголтыг эзэмшүүлэх
- М.5** Материаллаг эрх зүйн ойлголт, эрх зүйн харилцаа, хэм хэмжээ, тогтолцоо, институт хоорондын уялдаа холбооны талаарх мэдлэгийг эзэмшүүлэх
- М.6** Процессын эрх зүйн ойлголт, эрх зүйн харилцаа, хэм хэмжээ, тогтолцоо, институт хоорондын уялдаа холбооны талаарх мэдлэгийг эзэмшүүлэх
- М.7** Үндэсний болон олон улсын эрх зүйн болон эрх зүйн бусад бүлийг харьцуулан судалж, онцлогийн талаарх мэдлэгийг эзэмшүүлэх
- М.8** Хууль зүйн шинжлэх ухааны тулгуур ойлголт, түүний бүрдэл хэсгийг танин мэдэх, тайлбарлах, хэрэглэх мэдлэгийг эзэмшүүлэх
- М.9** Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх арга зүйн мэдлэгийг эзэмшүүлэх
- М.10** Гадаад хэлийг харилцааны болон мэргэжлийн үйл ажиллагаанд ашиглах түвшинд эзэмшүүлэх
- М.11** Эрүүл аж төрөх ёсны дадлыг эзэмшүүлэх

#### Ур чадвар

- Ч.1** Нийгмийн үзэгдэл, харилцаа, үйл явцыг нийгэм, хүмүүнлэг, эдийн засаг, эрх зүйн шинжлэх ухааны суурь онол, арга зүйгээр задлан шинжилж, тайлбарлах, эдгээр шинжлэх ухааны аргуудыг мэргэжлийн болон нийгмийн янз бүрийн хэлбэрийн үйл ажиллагаанд хэрэглэх
- Ч.2** Амьд болон амьгүй байгаль дахь үзэгдэл, үйл явцын тухай бүрэн дүүрэн төсөөлөлтэй, байгалийг танин мэдэх шинжлэх ухааны орчин үеийн аргуудын боломжийг ойлгосон, тэдгээрийг мэргэжлийн үүргээ биелүүлэхэд ашиглаж чаддаг байх
- Ч.3** Сэтгэлгээний соёлыг эзэмшсэн, байгаль нийгмийн хөгжлийн ерөнхий хуулиудыг мэддэг, өөрийн санаа бодлыг зөв илэрхийлэх
- Ч.4** Бие даан болон багаар ажиллах чадвартай, ажлын зохион байгуулалт, харилцааны соёлтой, илтгэх, баримт бичиг боловсруулах, монгол хэлээр найруулан бичих

- Ч.5** Шинжлэх ухааны хөгжил, нийгмийн хурдацтай хөгжлийн үед өөрийн үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх чадвартай, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан шинэ мэдээ, мэдээлэл олж авах, бүтээлчээр, тасралтгүй бие даан суралцах
- Ч.6** Эзэмшиж буй мэргэжлийн үйл ажиллагааны өөрчлөлтөд сэтгэл зүйн хийгээд арга зүйн бэлтгэлтэй байх
- Ч.7** Эзэмшиж буй мэргэжлийн мөн чанар, нийгэмд үйлчлэх ач холбогдол, түүний үйл ажиллагаа дахь үндсэн асуудлуудыг ойлгож, тэдгээрийг иж бүрэн бүрдэл системд нь авч үздэг байх
- Ч.8** Өөрийн мэргэжлийн үүргээ биелүүлэхтэй холбоотой зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлох чадвартай, тэдгээрийг шийдвэрлэх арга замын сонгож хэрэглэх
- Ч.9** Эрх зүйн орчны хийгээд хүн нийгмийн харилцааны үйл ажиллагааны онцлог, нийгэм, түүний тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд тэдгээрийн нөлөөлөх нөлөөг тодорхойлж чаддаг байх
- Ч.10** Эрх зүйн шинжлэх ухаан, эрх зүйн үндсэн салбаруудын ойлголт, ухагдахууны арга зүйг эзэмшсэн, түүнд анализ хийх, ирээдүйн хандлагыг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглах
- Ч.11** Олон улсын эрх зүйн үйл явц болон орчин үеийн Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд хамаарах асуудлуудад дүн шинжилгээ хийх
- Ч.12** Нийгэм эрх зүйн өнөөгийн тулгамдсан асуудлаар судалгаа шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, түүнийгээ шийдвэр гаргагчид болон хамаарах субъектэд нотлох
- Ч.13** Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх
- Ч.14** Хэрэг маргаанд эрх зүйн дүн шинжилгээ хийх, хууль зүйн дүн шинжилгээ хийх, хууль зүйн дүгнэлт боловсруулах, шийдвэр гаргах

#### **Хандлага**

- Х.1** Иргэний ардчилсан нийгмийн суурийг бүрдүүлэгч үнэт зүйлсийг мэддэг, бусад үндэстэн, бүс нутаг, улс үндэстнийхээ түүх, соёлын өвийг олон ургалч агуулгаар ойлгон хүндэтгэх үзэл төлөвшсөн, тэдгээрийг тайлбарлах, баяжуулах чадвартай, эх оронч үзэлтэй, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг байх
- Х.2** Бусдын үзэл бодлыг хүндэтгэх, удирдлагын оновчтой шийдвэр гаргах, өөртөө болон бусдын өмнө хариуцлагатай байх
- Х.3** Эрх чөлөө, тэгш байдал, ардчилсан ёс, үндэсний эв нэгдэл, хууль дээдлэх ёс, шударга ёсыг эрхэмлэх
- Х.4** Ёс зүйн болон эрх зүйн хэм хэмжээг танин мэдэх замаар амьдрал, үйл ажиллагаандаа харгалзах

### **Сургалтын төлөвлөгөөний бүтэц**

Эрх зүйн бакалаврын хөтөлбөрийг өдөр, эчнээ, орой гэсэн гурван сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж байна.

1. Өдрийн хэлбэрээр сургалтын төлөвлөгөө нь нийт 151-170 багц цагийн багтаамжтайгаар 10 улиралд явуулахаар баталсан. Үүнд:

Эрх зүйн хөтөлбөрийн бүтэц (Өдрийн анги буюу 5 жил)	Багц цаг			
	Эрх зүй	Японы эрх зүй	Солонгосын эрх зүй	Олон улсын эрх зүй
А.Ерөнхий суурь хичээл			31	
Б.Мэргэжлийн суурь хичээл				
Б1.Заавал судлах хичээл (33)			37	
Б2.Сонгон судлах хичээл (4)				
В.Мэргэжлийн хичээл			68-87	
В1. Заавал судлах	58	58	58	60
В2. Сонгон судлах	10	27	27	10
Чөлөөт сонголтын хичээл	15			15
<b>Нийт</b>	<b>151</b>	<b>153</b>	<b>153</b>	<b>153</b>
<b>Эчнээ буюу 3.5 жил</b>				
А.Мэргэжлийн суурь хичээл				
А1.Заавал судлах хичээл (33)	37			
А2.Сонгон судлах хичээл (4)				
В.Мэргэжлийн хичээл				
В1.Заавал судлах хичээл (43)	61			
В2.Сонгон судлах хичээл (18)				
<b>Нийт</b>	<b>98</b>			
<b>Орой буюу 2.5 жил</b>				
А.Мэргэжлийн суурь хичээл				
А1.Заавал судлах хичээл (33)	37			
А2.Сонгон судлах хичээл (4)				
В.Мэргэжлийн хичээл				
В1.Заавал судлах хичээл (43)	61			
В2.Сонгон судлах хичээл (18)				
<b>Нийт</b>	<b>98</b>			

### Хөтөлбөрийн хичээлийн онол, практикийн харьцуулалт

Өөрийн үнэлгээний тайланд Эрх зүй бакалаврын хөтөлбөрийн өдрийн буюу 5 жилийн 151 багц цаг судлах сургалтын төлөвлөгөөнд суурилж хөтөлбөрийн агуулгын онол, практикийн харьцааны талаар авч үзсэн. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан нийт 151 багц цагийн 105 буюу мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээл байх бөгөөд ерөнхий суурь, чөлөөт сонголтоор судлах хичээлийн багц цаг 46 байна. Энэ нь 105/46 буюу 63.5/36.5 хувийн харьцаатай байна.

Өдрийн ангийн оюутан 6 багц багийн үйлдвэрлэлийн буюу хууль зүйн дадлагын 9 дүгээр улиралд, эчнээ ангийн оюутан 2 багц цагийн үйлдвэрлэлийн буюу танилцах дадлагыг 6 дугаар улиралд, оройн ангийн оюутан 2 багц цагийн үйлдвэрлэлийн буюу танилцах дадлагыг 4 дүгээр улиралд тус тус 16 долоо хоногийн хугацаанд өдөрт 4 цаг хийхээр төлөвлөгөөнд тусгажээ.

Түүнчлэн Төр, захиргааны хууль тогтоомжийн хэрэглээ, Иргэний хууль тогтоомжийн хэрэглээ, Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, Клиник-хууль зүйн туслалцаа хичээлүүдийг 5-7 дугаар улиралд 2-3 багц цагийн багтаамжтайгаар мэргэжлийн хичээлийн хүрээнд заавал судалдаг байна.

Танхимын сургалтаар олж авсан онолын мэдлэгийг практикт хэрэглэх, хуульчийн ажлын ур чадварт суралцан зохих дадал чадварыг эзэмшүүлэх Клиник сургалтыг 2 багц цагийн багтаамжтайгаар явуулах ба үүнийг Практик сургалтын төв зохион байгуулж



байна. Клиник сургалтын төвд практикийн туршлагатай багш нарыг гэрээгээр ажиллуулдаг. Клиник сургалтын хүрээнд оюутан хууль зүйн зөвлөгөө өгөх байранд бодит үйлчлүүлэгчид биечлэн болон зайнаас зөвлөгөө өгдөг байна. Тайлангийн хугацаанд 1491 иргэнд зөвлөгөө өгөх байранд, 388 иргэнд зайнаас, 1879 иргэнд багшийн удирдлага дор зөвлөгөө өгч ажиллажээ.

Практик сургалтын төвөөс зохион байгуулан УИХ-ын Тамгын газар, яам, агентлаг, шүүх, прокурор, өмгөөллийн 25 байгууллагатай оюутан дадлагажуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

### **Хөтөлбөрийн онцлог:**

Эрх зүйн хөтөлбөр Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль тогтоомжид нийцсэн байхаас гадна Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байхыг шаарддаг онцлогтой.

МУИС-ийн ХЗС-ийн хэрэгжүүлж буй эрх зүйн бакалаврын хөтөлбөр нь өдөр, орой, эчнээ гэсэн гурван хэлбэрээр сургалтыг явуулдаг, өдрийн анги нь 5 жил буюу 10 улиралд багтаан 151-153 багц цагийн хичээл судалдаг, эрх зүй, японы, солонгосын, олон улсын эрх зүй гэсэн дөрвөн мэргэшүүлэх багцыг сонгон судалж суралцдаг, чөлөөт сонголтын буюу МУИС-ийн бусад сургуулийн хичээлийг сонгон судлах боломж бий болгосон нь онцлог байна. Түүнчлэн үйлдвэрлэлийн дадлагын үр дүнд талууд сэтгэл ханамжтай байгаа болон клиник сургалтыг мэргэжлийн бөгөөд практик туршлага бүхий багшийн удирдлага дор явуулдаг нь сайн туршлага гэж үзэв.

Ажил олгогчдын зүгээс Практик сургалтын төвийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлснийг дурдах нь зүйтэй.

## Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### Илрэл нотолгоо:

БШУСайдын 2014 оны А/78 дугаар тушаалаар баталсан Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай, А/174 дүгээр тушаалд нийцүүлэн МУИС-ийн захирлын 2014 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/259 дүгээр тушаалаар баталсан, 2019 онд сургалтын төлөвлөгөөг шинэчилсэн.

МУИС-ийн захирлын “Журам батлах тухай” 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/347 дугаар тушаалаар МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмыг баталж 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж байгаа бөгөөд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны гишүүдийг томилж ахлагчаар Хууль зүйн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга, тэнхимийн эрхлэгч, дэд профессор нарын 9 профессор, ажил олгогч, төгсөгчийн төлөөлөл тус бүр нэг гишүүнтэй ажиллаж байна.

Өөрийн үнэлгээний тайланд Хөтөлбөрийн хорооны 2017-2021 оны үйл ажиллагааг хамруулан бичсэн бөгөөд 2017 онд шинээр байгуулсан хөтөлбөрийн хорооны баримт бичигт тулгуурлан бичсэн. Энэ хугацаанд Хөтөлбөрийн хороо 2018 онд 4 удаа, 2019 онд 2, 2021 онд 3 удаа, Нийтийн эрх зүйн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо 2019 онд 1 удаа тус тус хуралдаж сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

2019 онд Хайнс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академийн дэмжлэгээр Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй хамтран хийсэн Арилжааны (Худалдааны) хуулийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны үр дүнд үндэслэн Арилжааны эрх зүй, Арилжааны хэлцлийн эрх зүй, Арилжааны эрх зүйн хэрэглээ хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд нэмж тусган хэрэгжүүлжээ.

Өөрийн үнэлгээний тайланд хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлагад нийцүүлэх зорилгоор Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох судалгааны үр дүнд үндэслэн хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага байгаа болохыг баталж харуулсан.

Тайлангийн хугацаанд Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан 2018-2019, Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан 2018-2019, Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан (2019 оны төгсөгчид), Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан (2019 оны төгсөгчид), 2020 онд анх удаа Төгсөх түвшний суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг Оюутан төгсөгчийн хэлтсээс хийсэн ба судалгаанд хамрагдсан 7 салбар сургуулийн оюутны 4.4 хувь буюу

Хууль зүйн сургуулиас 26 төгсөх түвшний оюутан оролцсон. Голч дүнгийн мэдээлэлд тулгуурлан эрэмбэлэхэд ХЗС-3.04 буюу МУИС-ийн хэмжээнд 3 дугаарт эрэмбэлэгдсэн. Судалгаанд хамрагдсан оюутны 47.4-66.7 хувь нь сургалтын хөтөлбөрийн талаар эерэг үнэлгээ, сургалтын үйлчилгээний талаар 47.9-62.9 хувь нь эерэг үнэлгээг тус тус өгсөн. Дадлагын хичээлийн талаар танилцах дадлагын үр дүнг тааруу, үйлдвэрлэлийн дадлагын үр дүнг илүү хэмээн үнэлжээ.

Эдгээр судалгааны үр дүнг тэнхим болон сургуулийн захиргааны болон бусад зөвлөл, хороогоор хэлэлцэж байгаагүй, тэнхим, багш тус бүрд нь мэдээллийг хүргэж ажилладаг талаар тайлбар өгсөн болно. Түүнчлэн үйлдвэрлэлийн дадлагын удирдагч нараас асуулга авдаг талаар ажил олгогч, оюутны төлөөлөлтэй уулзалт хийх үеэр яригдсан боловч сургууль, тэнхим, хөтөлбөрийн хорооны түвшинд хэлэлцэж байсан баримт байхгүй. Өөрийн үнэлгээний тайлан боловсруулах баг үүнд дүгнэлт хийж холбогдох судалгааг хийж байх, “сургалтын хөтөлбөрөө байнга сайжруулах шаардлага оршсоор<sup>3</sup> байна” гэж дүгнэсэнтэй санал нэг байна.

Монгол Улсын эрх зүйн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа 15 их, дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад хамгийн багц цаг судалдаг, 5 жилийн сургалт явуулж байгаа нь МУИС-ийн хэрэгжүүлж буй либерал арт сургалтын тогтолцоо болон мэргэшүүлэх, хууль хэрэглээний ур чадварт анхаарч байгаатай холбоотой.

Япон Улсын Цүкүбагийн их сургууль, Чюогийн их сургууль, Нагояагийн их сургууль, мөн их сургуулийн Азийн эрх зүйн солилцооны сургалтын төв, ХБНГУ-ын Вурцбергийн их сургууль, Байротын их сургууль, Мюнхений их сургууль, АНУ-ын Пенсилваний их сургууль, ОХУ-ын Москвагийн их сургууль, Нидерланд улсын Утрехтын их сургуулийн хуулийн факультет, Хойд Ирландын хатан хааны их сургууль, Хонконгийн их сургууль, Сингапурын их сургууль, БНСУ-ын Чонбукын их сургууль, Күүминий их сургууль, БНХАУ-ын Ренминий их сургууль, зэрэг сургуулийн үйл ажиллагаа, эрх зүйч мэргэжлээр бакалаврын боловсрол олгох хөтөлбөрийг судалж туршлага судалж байсан. Энэ талаарх туршлага судалсан, ажлын айлчлал хийсэн багш нарын тайлантай танилцсан. Тайланг хэлэлцсэн болон бусад багш нарт мэдээлэл өгсөн баримт байхгүй байсан болно. Түүнчлэн тайлангийн хугацаанд сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан үед эдгээр харьцуулсан судалгаагаа ашигласан тухай баримтжуулсан зүйл байхгүй байсан.

Өөрийн үнэлгээний тайлангийн хамрах хугацаанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудыг тодорхойлох судалгаа хийгээгүй. Ажил олгогч, төгсөгч, оюутан, багш нараас сэтгэл ханамжийн судалгаа авсан, төгсөгчийн мөшгөх судалгааг эхлээд явж байгаа болох нь өөрийн үнэлгээний тайлан, сургууль дээр ажиллах үед тогтоогдсон. Гэвч авсан судалгааны үр дүнг хэлэлцэж баталгаажуулсан нотлох баримт байхгүй байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход их сургууль болон бүрэлдэхүүн сургуулиас явуулж байгаа судалгаа шинжилгээнүүдээс гадна холбогдох мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа зэргийг ашигласан байна.

Эрх зүйн хөтөлбөр Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хууль тогтоомжид нийцсэн байхаас гадна Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байхыг шаарддаг онцлогтой.

---

<sup>3</sup> Өөрийн үнэлгээний тайлангийн 15 дахь тал.

МУИС-ийн ХЗС-ийн хэрэгжүүлж буй эрх зүйн бакалаврын хөтөлбөр нь өдөр, орой, эчнээ гэсэн гурван хэлбэрээр сургалтыг явуулдаг, өдрийн анги нь 5 жил буюу 10 улиралд багтаан 151-153 багц цагийн хичээл судалдаг, эрх зүй, японы, солонгосын, олон улсын эрх зүй гэсэн дөрвөн мэргэшүүлэх багцыг сонгон судалж суралцдаг, чөлөөт сонголтын буюу МУИС-ийн бусад сургуулийн хичээлийг сонгон судлах боломж бий болгосон онцлогтой байна гэж үзлээ.

#### **Анхаарах асуудал:**

Хийсэн судалгаагаа сургалтын үйл ажиллагааны сайжруулалтад ашиглах, явуулж буй үйл ажиллагаагаа баримтжуулахад анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Оролцогч болон сонирхогч талуудыг тодорхойлох болон тэдгээрийн хэрэгцээ, хүлээлтийн судалгааг хийх
- МУИС-ийн холбогдох алба нэгжээс зохион байгуулж явуулсан, ХЗС-аас авсан аливаа судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалт хийхэд тогтмол ашиглах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

Олон улсын Ажил, мэргэжлийн Стандарт Ангилал-88 (ISCO-88)-д нийцүүлэн ҮАМАТ-08-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар тушаалаар “Үндэсний ажил, мэргэжил, албан тушаалын жагсаалт, ангилал, тодорхойлолт”-ыг батлан мөрдүүлсэн.

Энэхүү ангиллын 26 дугаар индексэд Хууль, нийгэм соёлын мэргэжилтэн ангиллын 261.Эрх зүйч мэргэжилтний 2611-т Эрх зүйч (Хуульч) мэргэжлийн тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг болон эрхэлж болох албан тушаалын жишээг тодорхойлсон. Үүнд эрх зүйч нь өргөн хүрээтэй асуудлаар үйлчлүүлэгчдэд хуулийн зөвлөгөө өгөх, бичиг баримт бүрдүүлэх, үйлчлүүлэгчийг захиргааны болон бусад шүүх болон шүүх хуралд төлөөлөх, эсвэл яллагчаар оролцох, юм уу дээд шатны шүүхэд давж заалдах талаар зөвлөгч байх ба дараа үүргийг гүйцэтгэхээр тодорхойлжээ:

- а) Үйлчлүүлэгчид өргөн хүрээтэй асуудлаар хуулийн зөвлөгөө өгөх, түүний өмнөөс хуулийн ажиллагаа хийх,
- б) Хууль зүйн зарчим, дүрэм, тухайн хэргийн асуудлаар өмнөх шатны шүүхээс гарсан шийдвэрийг судлах,
- в) Хуулийн, юм уу өмгөөллийн ямар нэг арга хэмжээ авах зорилгоор нотлох баримт бүрдүүлэх, асуудлыг тодорхой болгохын тулд үйлчлүүлэгч болон гэрчийн этгээдтэй ярилцлага хийх,
- г) Хэргийг хэлэлцэхэд бэлтгэж олж авсан мэдээллийг үнэлэх, мэтгэлцээний талаар стратеги бэлтгэх,
- д) Үйлчлүүлэгчийн хэргийг шүүх, захиргааны шүүхэд төлөөлөх, зохих шатны шүүхэд давж заалдаж болох талаар зөвлөгөө өгөх,
- е) Дээд шатны шүүхэд давж өмгөөлөл хийх
- ж) Төрийг төлөөлж яллагчаар оролцох,

- з) Хуулийн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд хэлэлцээ хийх,
- и) Хуулийн төсөл боловсруулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад үндэслэн Засгийн газрын журам боловсруулах
- к) Гэрээ хэлэлцээр, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, гэрээслэл, хуулийн байр суурь илэрхийлэх бичиг баримт бэлтгэх.

ҮАМАТ-08-д ангилснаар эрх зүйч ангилалд шүүгчийн ажил мэргэжлийг бие даасан ангилалд оруулсан ба эрх зүйч нь өмгөөлөгч, прокурор, нотариатч, хуулийн ажилтан зэрэг ажил эрхлэх боломжтой. МУИС-ийн ХЗС Эрх зүйн хөтөлбөрийг шүүгч төвтэй мэргэжилтэн бэлтгэхэд анхаарч ирсэн ба сүүлийн жилүүдэд төгсөгчид хууль зүйн тусалцаа үзүүлэх чиглэлээр ажиллах нь нэмэгдсэнтэй<sup>4</sup> холбогдуулан өмгөөлөл, хууль зүйн зөвлөгч болоход бэлтгэхэд хөтөлбөрийг чиглүүлэн ажиллаж байгаа тухай өөрийн үнэлгээний тайландаа дурдсан байгаа нь дээр олон улсын болон үндэсний мэргэшлийн хүрээнд нийцүүлэн ажил хийгдэж байна гэж хэлж болно.

Хөтөлбөрийн зорилгыг “Бүрэн дунд боловсролтой иргэнийг нийгмийн идэвхтэй гишүүн байхад зайлшгүй шаардлагатай бүтээлч, логик сэтгэлгээтэй, санаачилгатай, шинжлэх ухаанч шийдвэр гаргадаг, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэг эзэмшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн мэдлэг, ур чадвартай дээд боловсролтой иргэн болгон төлөвшүүлэхэд оршино” хэмээн тодорхойлсон ба Сургалтын хөтөлбөр боловсруулахдаа МУИС-ийн болон ХЗС-ийн зорилгын нийцлийг авч үзсэн байна.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг сургалтын хөтөлбөрийн 10 дугаар талд тодорхойлсон боловч энэ шалгууртай холбоотой SWOT шинжилгээний Сул тал, Боломж дээр хүрэх үр дүн, зорилгод судалгаа хийж байгаагүй талаар дурдсан.

Өмнө дурдсанчлан оролцогч болон сонирхогч, хэрэглэгч талуудыг тодорхойлоогүй тул тэдгээрийн хэрэгцээ, шаардлагад хөтөлбөрийн зорилго нийцэж байгаа эсэхийг үнэлэх боломжгүй байсан. Гэвч үндэсний мэргэшлийн хүрээ, олон улсын болон үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт болон МУИС, ХЗС-ийн эрхэм зорилго, зорилгод хөтөлбөрийн зорилгыг нийцүүлэн боловсруулсан тул цаашид хэрэглэгчийн, оролцогчийн, сонирхогчийн хэрэгцээ шаардлагыг судалж түүний үр дүнд үндэслэн хөтөлбөрийн хөгжүүлэлтийг хийх боломж байна гэж үзсэн. Өөрийн үнэлгээний тайлан боловсруулсан баг ч цаашид хийх зүйл их байгаа гэдгийг ойлгож мэдэрсэн тухай танилцуулсан болно.

### **Онцлог зүйл/Гуршлага:**

Хөтөлбөрийн боловсруулалт хийхдээ их сургууль болон хууль зүйн сургуулийн эрхэм зорилгод хөтөлбөрийн зорилгыг нийцүүлэх, нийцлийн матриц хийх зэргээр ажилласан байна.

### **Анхаарах асуудал:**

- Хууль зүйн сургуулийн зорилгыг зохих шийдвэр гаргах эрх бүхий этгээдээр баталгаажуулах, хөтөлбөрийн зорилгыг хөтөлбөр дээр бичсэн байгаагаар шинжээчийн тайланд тусгасан бөгөөд өөрийн үнэлгээний тайланд хөтөлбөрийн зорилгыг өөрөөр бичсэн байгаа алдааг залруулах, их сургууль, бүрэлдэхүүн сургууль, хөтөлбөрийн зорилгыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч буюу ХЗС-ийн нийт багш, албан хаагчид таньж мэдүүлэх, хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд хүн бүрийн идэвх оролцоог хангах байгууллагын соёл тогтооход анхаарч ажиллах нь зүйтэй.
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа хийж байх.

---

<sup>4</sup> ӨҮТ-ийн 58 дахь тал.

## **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг үндэсний мэргэшлийн хүрээ ба хөтөлбөрийн нийцлийг авч үзэж дүн шинжилгээ хийдэг байх.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилгод судалгаа хийж үйл ажиллагаандаа ашиглах.
- “Хөтөлбөрийн зорилго нь хичээлийн хөтөлбөрт тусгагдсан эсэх талаар үнэлгээ хийж, цаашид сайжруулахад төвөгтэй байх” гэсэн өөрийн үнэлгээний багаас тодорхойлсон эрсдэлийг сааруулах, бууруулах, арилгах талаар зохих ажлыг зохион байгуулах.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

БШУСайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар баталсан Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг баталж мөрдөж байна (Хүснэгт №1).

Хүснэгт №1. Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцсэн байдал

<b>Сургалтын төлөвлөгөөний бүтэц</b>	<b>Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага</b>	<b>ХЗС-ийн Эрх зүй хөтөлбөр</b>
Ерөнхий суурь	30 хувиас илүүгүй	31 багц цаг буюу 20.5 хувь
Мэргэжлийн суурь	25 хувиас илүүгүй	37 багц цаг буюу 24.5 хувь
Мэргэжлийн хичээл	45 хувиас доошгүй	68 багц цаг буюу 55 хувь

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3-ын 3.2.10-т “2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах” гэж заасан. Сургалтын төлөвлөгөөнд тусгасан ерөнхий суурь хичээлийн “Яриа, бичгийн ур чадварын чиглэл”-ийн Монгол хэл бичиг, найруулга зүйн хичээлээр энэ агуулга багтдаг гэх боловч хичээлийн хөтөлбөртэй танилцах боломж олдоогүй ба ийм агуулга судалсан оюутан уулзалтад байгаагүй болно.

Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба хөтөлбөрт багтсан хичээлүүдийг уялдаа холбоог хангаж матриц хийсэн бөгөөд суралцахуйн үр дүнд чиглэсэн сургалтын арга хүргэх хэлбэрүүд, сургалтын үнэлгээг сургалтын үр дүнгийн гүйцэтгэлийн түвшнийг үнэлэх шууд болон шууд бус үнэлгээний аргыг тодорхойлсны дагуу сургалтыг зохион байгуулдаг.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график, хөтөлбөрийн /PLO/ болон хичээлийн /CLO/ суралцахуйн үр дүнгийн төлөвлөлтийг уялдуулж боловсруулсан байна.

Сургалтын үр дүнгийн талаар ажил олгогч, оюутны, төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2018 оноос хойш авч байгаа, үйлдвэрлэлийн дадлагын удирдагчаас санал асуулга авдаг талаар ажил олгогч болон төгсөгчтэй хийсэн уулзалт ярилцлагын үеэр дурдаж байсан.

Ажил олгогчдын хувьд хичээлийн ачаалал өндөр, түүндээ их анхаарч цагаа зарцуулдаг учраас оюутны нийгмийн оролцоо бага байдагт шүүмжлэлтэй хандсан бөгөөд цаашид хос мэргэжил буюу эрх зүй-бизнес, эрх зүй-мэдээллийн технологи, эрх

зүй-антрологи, эрх зүй-криминологи, мэргэжлийн англи хэл нэмэх зэрэг санал гаргасныг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй.

Энэ нь нөгөө талаас оюутны бизнесийн, мэдээллийн технологийн зэрэг дээр дурдсан бусад мэдлэгийн салбарын мэдлэг, ур чадвар дутагдаж байгаагийн илрэл байж болохыг үгүйсгэхгүй.

**Онцлог зүйл/Туршлага:**

МУИС-аас хэрэгжүүлж буй Либерал арт сургалтын арга зүйг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

**Анхаарах асуудал:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3-ын 3.2.10-т “2020-2021 оны хичээлийн жилээс их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд монгол бичгийн хичээлийг заавал судлах” гэж заасан тул энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч-оролцогч тал болох ерөнхий суурь хичээлийг заадаг сургууль тэнхимтэй хамтран шийдвэрлэх замаар нийцлийг хангах.

**Зөвлөмж:**

Сонирхогч, оролцогч талуудыг оролцоог хангах, тэдгээрийн санал зөвлөмжийг үйл ажиллагаагаа болон хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусган ажиллах, тэдгээрийг баримтжуулж хэвших.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

МУИС-ийн хууль зүйн сургуулийн бакалаврын эрх зүй хөтөлбөрийг МУИС-ийн захирлын 2014 оны А/20 дугаар тушаалаар баталж 2019 онд сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж тайлангийн хугацаанд 7 удаа өөрчлөлт орсон байна.

МУИС-ийн хууль зүйн сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь их сургуулийн эрхэм зорилгод нийцсэн, эрх зүй бакалаврын хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүйгээ хөгжүүлэхэд анхаарч ажиллаж иржээ. Хичээлийн жилийн туршид хоёр удаа оюутны сэтгэл ханамжийн судалгаа, багш нараас өөрийн үнэлгээний тайланг нэг удаа авч дүн шинжилгээ хийдэг. Оюутны сэтгэл ханамжийн судалгааг мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан СиСи программын туслалцаатайгаар авч багш нэг бүрд өөрт нь хүргэдэг, багш өөрөө тухайн судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж арга зүй, хичээлийн агуулгыг хөгжүүлдэг.

Тайлангийн хугацаанд нэг улиралд орж буй нийт хичээлийн 25-36.7 хувь нь хоёр буюу түүнээс дээш тооны багшаас сонгох боломжоор хангасан<sup>5</sup> бөгөөд хичээл болон багш сонголтын талаар МУИС-ийн захирлын 2015 оны А/03 дугаар тушаалаар баталсан Сургалтын журмын 4.5.1-т заасан<sup>6</sup>. Тухайлбал, багш улирлын 11 дэх долоо хоногт дараагийн улиралд заах хичээлийн саналаа тэнхим, сургалтын албанд өгөх, суралцагч улирлын 13-14 дэх долоо хоногт багтаан дараагийн улиралд судлах хичээлийн саналаа өгнө.

МУИС-ийн сургалтын журам болон стратегийн баримт бичигт оюутан багшийн зохистой харьцааг 15:1 байхаар тогтоосон боловч 2016-2017 оны хичээлийн жилд 25:1 байсан бол 2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар 44:1 болж өссөн байна.

Практик сургалтын төвөөс зохион байгуулан УИХ-ын Тамгын газар, яам, агентлаг, шүүх, прокурор, өмгөөллийн 25 байгууллагатай оюутан дадлагажуулах гэрээг 1-2 жилийн хугацаатайгаар байгуулан ажиллаж байна<sup>7</sup>.

Бакалаврын хөтөлбөрийн оюутны улиралд дунджаар 15 багц цагийн хичээл судлах боломжтой байхаар сургалтыг төлөвлөсөн, тайлангийн хугацаанд нэг оюутан дунджаар 14.7-17.1 багц цагийн хичээлийн нэг улиралд судалсан нь зохистой хэмжээнд байна гэх үндэслэл болох бөгөөд судалбал зохих багц цагийн доод хэмжээ 12, дээд хэмжээ 21 байхаар тогтоожээ.

Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр нь онол, практикийн зохистой харьцаа, үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хэрэгжүүлдэг байдал, хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал, суралцагчийн цагийн ачааллыг хэрхэн тооцдог талаар ӨҮТ-д дүн шинжилгээ хийж үнэлгээ, дүгнэлт өгчээ.

<sup>5</sup> ӨҮТ-ийн 41 дэх тал.

<sup>6</sup> ӨҮТ-ийн 40 дэх тал.

<sup>7</sup> ӨҮТайлангийн хавсралт №2.6



Хөтөлбөрийн дагуу судлах хичээлүүдийн залгамж холбоог хичээлийн агуулга, суралцахуйн үр дүнд үндэслэн гаргадаг. 2016 оны сургалтын төлөвлөгөөгөөр “хэрэглээ” хичээлийг судалсны дараа үйлдвэрлэлийн дадлага хийдэг байсан бол 2019 онд шинэчилсэн төлөвлөгөөгөөр Үндсэн хуулийн, Захиргааны, Эрүүгийн, Иргэний “процессын эрх зүй” хичээлийг судалсны дараа үйлдвэрлэлийн дадлагыг сонгох боломжтой болгон өөрчилж, Арилжааны эрх зүй, арилжааны хууль тогтоомжийн хэрэглээ хичээлийг заавал судлах мэргэжлийн хичээлд нэмж баталсан. ӨҮТ-д эрх зүй, олон улсын эрх зүй, Японы эрх зүй, Солонгосын эрх зүй, эчнээ ангийн хичээлийн уялдаа холбооны модыг зургаар гаргаж харуулсан.

2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар сургалтын төлөвлөгөө дэх хичээлийн онол, практикийн харьцаа нь 53.3:36.7 байна гэж тооцсон. Сургалтыг танхимын сургалт, үйлдвэрлэлийн дадлага, бакалаврын судалгааны ажил гэсэн төрлөөр явуулах ба танхимын сургалт нь лекц, семинарын хэлбэртэй, лекцийн хичээлээр олж авсан мэдлэгийг семинарын хичээлээр бататгах, кейс дээр ажиллах, тохиолдол шинжлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэргээр хууль тогтоомжийн хэрэглээ хичээлүүдээр ур чадвар олгох сургалтыг явуулж байна.

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт хичээлийн 66.5-67 хувь нь онолын, 38-38.5 хувь нь практикийн буюу 63.5 хувь нь онолын, 36.5 хувь нь практикийн хичээл байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

Арилжааны эрх зүй, арилжааны хууль тогтоомжийн хэрэглээ хичээлийг заавал судлах мэргэжлийн хичээлд нэмж баталсан.

#### **Анхаарах асуудал:**

ХЗС-ийн хувьд багш:оюутны тооны харьцаа 2016-2017 оны хичээлийн жилд 25:1 байсан бол 2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар 44:1 болж өссөн. Цаашид зохистой хэмжээнд хүртэл бууруулах шаардлага үүссэн байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа эсэх талаар судалж дүн шинжилгээ хийх
- Багш сонголтын хувийг нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлэх. МУИС-ийн сургалтын журам болон стратегийн баримт бичигт оюутан багшийн зохистой харьцааг 15:1 байхаар тогтоосныг баримтлах.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

МУИС-ийн стратегийн тэргүүлэх чиглэлийн нэг нь “сурах ба багшлах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” гэж зааж Сургалтын журамд хичээлийн арга зүйн ерөнхий хэлбэрийг тусгасан. Эдгээр баримт бичигт үндэслэн МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмыг хэрэгжүүлэх товч заавар, түүний хавсралт хичээлийн хөтөлбөр боловсруулах зааврын дагуу хичээлийн хамтлаг, хичээл тус бүрээр тохирох арга зүйг

хөтөлбөрийн болон хичээлийн хөтөлбөрт тусган тэнхимийн хөтөлбөрийн хороогоор баталгаажуулсан.

Оюутан сургалтын үр дүнг эрүү, иргэн, захиргааны эрх зүй зэрэг судалгааны салбар тус бүрээр багшийн заах арга зүй, нийт суралцагчийн тоо, оролцоо зэргийг харгалзан тооцож сургалтын хэлбэрүүдийг үр нөлөөтэй ашиглах ба бие даан сурах үйл явцтай хослуулдаг байна.

Сургалтад кейс шийдвэрлэх, бодлого бодох түүнчлэн шүүхийн шийдвэрт анализ хийх Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан аргачлал ашиглах, дүрд тоглуулах зэрэг аргыг түлхүү ашигладаг. Өөрийн үнэлгээний тайлангийн хавсралт №2.7-д суралцахуйн үр дүн ба сургалтын арга, хүргэх хэлбэрийн хамаарлыг тодорхойлон гаргасан нь хөтөлбөрийн зорилго, цогц чадамж олгоход суурилсан, суралцагч төвтэй хөтөлбөр болсон гэх үндэслэл болж байна.

Түүнчлэн их сургуулийн үйл ажиллагаанд сургалтын нэгдсэн удирдлага мэдээллийн системийг нэвтрүүлж тогтвортой ашиглаж байгаа бөгөөд оффис 365 программыг албан ёсны лицензтэйгээр авч ашигладаг, зарим цахим ном, бүтээлийн санд албан ёсны эрхтэйгээр хандах зэргээр мэдээллийн технологийн ололт, дэвшлийг ашиглаж байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

Сургалтын идэвхтэй аргуудыг ашигладаг, улирал тутам оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар багшийн заах арга зүй, үнэлгээний аргачлал, зөвлөн тусалдаг байдал зэрэг сургалтын арга зүйн талаар тухайлсан асуулга авч багшид өөрт нь мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд оюутантай хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын нэгжээс уулзаж ярилцан тодруулга авдаг байна.

### **Анхаарах асуудал:**

Хөтөлбөрийн оролцогч талууд болох багш, оюутан, төгсөгчид удирдлага мэдээллийн систем доголддог талаар сэтгэл ханамж хангалтгүй байгааг анхаарч залруулах шаардлагатай.

### **Зөвлөмж:**

Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийх.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

МУИС-ийн захирлын 2015 оны А/203 дугаар тушаалаар баталсан МУИС-ийн сургалтын журмын 4.6.1-д заасны дагуу Эрх зүй бакалаврын хөтөлбөрийн суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж байна. Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх гол хэлбэр нь шалгалт байх ба нийт 100 оноогоор дүгнэнэ.

Оюутны хичээлийн идэвх оролцоонд ирц, семинар, дадлага, хичээлд бэлтгэсэн байдалд 20-40 оноог багш, улирлын явцын шалгалтын оноо 20-40, улирлын шалгалтын үнэлгээ 20-60 оноо байна. Энэ онооны дээд доод хязгаарт багтаан багш өөрийн хичээлийн үнэлгээний задаргааг хичээлийн хөтөлбөрт тусган сургуулийн цахим хуудастай

байрлуулахаас гадна оюутнуудад зориулсан уламжлалт өдөрлөгийн үеэр дэлгэрэнгүй танилцуулдаг.

Оюутан удирдлага мэдээллийн систем дэх өөрийн хувийн бүртгэл хэсэгт нэвтэрч үнэлгээний задаргааг үзэж танилцах эрхтэй ба санал нийлэхгүй тохиолдолд дараагийн улирал эхэлснээс нэг сарын дотор сургалтын албанд хүсэлт гарган шийдвэрлүүлэх боломжтой. Сургалтын журмын 4.6.12.2-т зааснаар 60 ба түүнээс дээш оноо авсан оюутын тухайн хичээлийн багц цагийг хангасан үзнэ.

Өөрийн үнэлгээний тайланд хичээлийн жил тус бүрээр оюутны сурлагын дүнг голч оноогоор гаргаж амжилт, чанарыг гаргаж үзсэн боловч энэ талаар сургууль, тэнхим, хөтөлбөрийн хороо хэлэлцэж дүн шинжилгээ хийсэн баримт байхгүй.

Сургалтын хөтөлбөрт тухайн хөтөлбөрөөр суралцагчид олговол зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж баталж мөрдөж байгаа боловч хандлагыг хэрхэн үнэлэх талаар үнэлгээний системд тусгаагүй нь хөтөлбөрийн үр дүнг тооцох, хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

ӨҮТ-д суралцагчийн үнэлгээний арга, хэлбэр, хичээл тус бүрээр үнэлгээний онооны хуваарилалтыг гаргаж сурлагын дүнд дүн шинжилгээ хийсэн.

Эрх зүй бакалаврын хөтөлбөрт өөрийн үнэлгээ хийх явцдаа цахим сургалт явуулсан нөхцөлд үнэлгээний тусгай зохицуулалт шаардаж байгааг, өөрийн хөтөлбөрийн онцлогт тохирсон үнэлгээний аргуудыг боловсруулах шаардлага байгааг нээн илрүүлжээ.

#### **Анхаарах асуудал:**

Шинжилгээгээр илрүүлсэн сул тал, эрсдэлийг бууруулах, арилгах, түүнчлэн өөрийн үнэлгээгээр боломж гэж харж байгаа зүйлсийг хийж гүйцэтгэх анхаарах нь зүйтэй.

#### **Зөвлөмж:**

Суралцагчийн “хандлага”-ыг хэрхэн үнэлэх талаар хөтөлбөрт тусгасан хүрэх үр дүнтэй уялдуулан тогтоох.

Оюутны үнэлгээ, амжилт ахиц зэрэг статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх процессыг тодорхойлж зохицуулалт хийх.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:** Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин, нөхцөлтэй танилцлаа:

- Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль нь МУИС-ийн хичээлийн III байранд үйл ажиллагаа явуулдаг. Тус сургалтын орчин, анги танхимын хувьд техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна. Өөрийн үнэлгээний тайланд дурдсан нэг оюутанд ногдох талбай бага гэх боловч Хууль зүйн сургуулийн өргөтгөлийн барилга барихаар төлөвлөсөн нь уг асуудлыг шийдвэрлэх гарц болжээ.
- Хууль зүйн сургуулийн багш нарын бүтээл нь номын сангийн баяжилтын тодорхой хэсгийг бүрдүүлж, номын сангаас судалгаа хийж, эрэлт хэрэгцээний номыг татан төвлөрүүлэх ажил хийдэг нь сайн талтай боловч номын сангийн баяжилтад зарцуулах зардлыг бүрэн зарцуулах нь гэрээр ном олгох, оюутан бүрд номын хүртээмжийг хангахад ач холбогдолтой юм.
- Хууль зүйн сургуулийн өргөтгөлийн барилгын МЗХ2022/01-024 тоот Архитектур төлөвлөлтийн даалгавар 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан ба уг даалгавраар 34x16 хэмжээтэй 9 давхар боловсролын зориулалттай барилга барихаар төлөвлөсөн, мөн уг барилгын загвар зургийг барилгын зургийн тусгай зөвшөөрөл бүхий Эдшил ХХК зурсан байна. Төлөвлөсөн зурагт сургалтын орчин нөхцөлийг хангасан байна.
- Сургуулийн орчин нөхцөл болон анги танхим, номын сан, багш нарын өрөө, спорт заал, шүүх хуралдааны танхим, иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх танхим зэрэгтэй биечлэн танилцсан.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын техник тоног төхөөрөмж нь орчин үеийн шаардлага хангасан бөгөөд лекцийн танхимд агааржуулагч байршуулсан байна. Багш лекцийн хичээл заахад зориулсан лекцийн заалны тоног төхөөрөмж нь оюутанд мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх орчныг бүрэн хангасан байна.
- Практик сургалтын төвийн үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл буюу шүүх хуралдааны танхимд байх бүх шаардлага хангасан шүүх хуралдааны танхим, болон бичлэг хийх төхөөрөмж зэрэг нь шүүх хуралдааны бодитоор явуулах орчин нөхцөлийг хангасан байна. Мөн, иргэдэд зөвлөгөө өгөх танхим нь олон улсын жишгээр гадна талаас орох хаалга, уулзалтын өрөө зэрэг нь онцлох туршлагын нэг юм.

#### **Анхаарах асуудал:**

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын “Барилгын ашиглалтын төлөв байдлын тухай” 2022 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 02-07-395/86 дүгнэлтээр Монгол улсын их сургуулийн 3 дугаар байрны барилга 1956 онд ашиглалтад орсон, чулуун дүүргэлттэй, шугаман суурьтай даацын тоосгон хана, хөндлөн босоо ташуу хагарал, цууралт ихтэй, гадна хананы шавардлага ховхорч унасан. Шувуу нурууны модон хучилт өгөршиж муудсан, төмөр урагдсан, зэвд идэгдсэн. Гал гарах нөхцөл бүрдсэн, Газар хөдлөлтийн шаардлага хангахгүй байгаа гэх дүгнэлт гарсан нь цаашид уг байранд сургалтын үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал болохыг илэрхийлж байна.

#### **Зөвлөмж:**

Хууль зүйн сургуулийн өргөтгөлийн барилгын МЗХ2022/01-024 тоот Архитектур төлөвлөлтийн даалгавар 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан ба уг даалгавраар 34x16 хэмжээтэй 9 давхар боловсролын зориулалттай барилга барихаар төлөвлөсөн, мөн уг барилгын загвар зургийг барилгын зургийн тусгай зөвшөөрөл бүхий

Эдшил ХХК зурсан байна. Төлөвлөсөн зурагт сургалтын орчин нөхцөлийг хангасан шинэ сургуулийн барилгыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.

## **Шалгуурыг хангасан байдал: бүрэн хангасан**

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

##### **Сургалтын техник, хэрэгслийн хангамжид нийт**

- Нэг багшид ногдох компьютер болон принтерийн хангамж хангалттай.
- Сургалтын хэрэглэгдэхүүнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн баримттай нэг бүрчлэн танилцаж, ерөнхий нягтлан бодогчоор тайлбарлуулсан.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 117 дугаар тогтоолоор сургалтын техник хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл 21,474,234 төгрөгийн техник хэрэгсэл акталсан нь шинэчлэл байнга хийгддэг болохыг нотолж байна.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зорилгоор төслийн санхүүжилтийн сүүлийн 2 жилд нийт 103,000,000 төгрөгийн санхүүжилтээр нийт 11 төслийг дотоод төсвийн санхүүжилт олгосон баримттай танилцаж, уг санхүүжилтээр хэвлэгдсэн бүтээлтэй танилцсан.
- Багш нар сургалтын материалыг Си Си программд байршуулсан байдал болон багш нарын сургалтын үйл ажиллагаанд оюутнаас өгсөн үнэлгээтэй биечлэн танилцсан.
- Сургалтын үйл ажиллагаанд SiSi.num.edu.mn систем, эрдэм шинжилгээний менежментийн RMS систем, төслийн удирдлагын PMS систем болон олон улсын мэдээллийн ARDI, Jstor, EBSCO, HOST зэрэг сангуудын үйл ажиллагаатай танилцсан.
- Нийтийн болон хувийн эрх зүйн тэнхимийн багш нараас тохиолдлоор сонгож сургалтын иж бүрдэл хэрэглэгдэхүүнтэй танилцахад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хичээлийг удирдан явуулж байна.
- Монгол Улсын Их сургуулийн багшийн хөгжлийн төвийн дэргэд студи байгуулсан нь сургалтын хэрэглэгдэхүүнийг E контент түвшинд зохион байгуулах боломжийг хангаж байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зорилгоор төслийн санхүүжилтийг тогтмол олгож хэвшсэн.
- СиСи программаар дамжуулан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж хэвшсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутан, төгсөгч нартай уулзсан уулзалтад “хичээл сонголт болон дүн гарах үед Sisi программ ихээр гацдаг, явцын үнэлгээг мэдэх боломжгүй, хичээл сонголт хийхэд программын гацалт сөрөг нөлөө үзүүлдэг” гэх санал хүсэлтээс дүгнэхэд SISI программын шинэчлэл, хөгжүүлэлт хийх асуудалд анхаарах.
- Хууль зүйн сургууль нь өөрийн шинэ барилгад E контент хийх бие даасан студи байгуулах нь сургалтын хэрэглэгдэхүүнийг дижитал шилжилт хийхэд чухал ач холбогдолтой.

**Зөвлөмж:** Ярилцлагын нийтлэг дүнгээр хичээл сонголт болон дүн гарах зэрэг хандалт их авах ачаалалтай цаг хугацаанд Sisi программ ихээр гацдаг, явцын үнэлгээг мэдэх боломжгүй, хичээл сонголт хийхэд программын гацалт сөрөг нөлөө үзүүлдэг гэх санал хүсэлтэд анхаарч, цаашид дүгнэхэд SISI программын шинэчлэл, хөгжүүлэлт хийх.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн хууль зүйн сургууль болон МУИС-ийн төв номын сангийн Нийгмийн шинжлэх ухааны уншлагын танхим, номын биечлэн баяжилттай танилцсан. Номын сангийн баяжилт сүүлийн жилүүдэд тогтмол өсөж 30407 ном сургалтад ашиглаж байна.
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх сурвалж болох Коха болон catalog.num.edu.mn цахим программыг ашиглаж хэвшсэн. Энэхүү системийн хандалт тогтмолжсон байдалтай танилцсан.
- Монгол Улсын Их сургуулийн төв номын сан, эрдэм шинжилгээний номын сангийн хувьд орчин нөхцөл сайтай, номын фондын баяжилт хийгддэг сайн талтай байна. Мөн, Хууль зүйн сургуулийн мэргэжлийн номын сан нь нийт 55 уншигчийн суудалтай байгаа нь оюутанд хүртээмж багатай байна. Гэхдээ номын сангийн гэрээр олгох хэлбэр болон төв намын сангийн дотоод уялдаатай тогтолцоо нь уг асуудлыг шийдвэрлэх арга зам гэж үзэхээр байна.
- Номын сангийн танхимаар үйлчлүүлэх уншигчдын тоо бага байгаа нь байрны багтаамжтай шууд холбоотой. Шинэ байр нь ашиглалтад орсон тохиолдолд уг асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Оюутнуудтай уулзах уулзалтад “номын хүрэлцээ бага” гэж ярьсан ба сүүлийн 5 жилийн мэргэжлийн чиглэлийн номын баяжилттай танилцахад хангалттай байна.

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн багш нараас өөрийн судалгааны салбар чиглэлээр бүтээсэн ном сурах бичиг, нэг сэдэвт бүтээл болон судалгааны ажлаар номын сан жил бүр баяжилт хийдэг.
- Төв номын санд ном сэлбэх, засварлах, ариутгах төхөөрөмж байгаа нь шинэлэг төдийгүй номын сангаар үйлчлүүлж байгаа уншигчдын эрүүл мэндэд нэн шаардлагатай байна.
- Диссертаци, магистрын болон бакалаврын дипломын ажлын цахим санг бүрдүүлж уншигчдын хүртээл болгож байгаа нь ач холбогдолтой.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн удирдлагын хувьд захиргааны зөвлөл болон хөтөлбөрийн дэд хороо үйл ажиллагаа явуулж байна.
- Монгол Улсын Их сургуулийн захирлын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/323 дугаар тушаалаар Хууль зүйн сургуулийн хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүний ахлагчаар Б.Амарсанаа, гишүүдэд проф Д.Баярсайхан, дэд проф М.Уянга, Б.Улаанбаатар, Т.Мэндсайхан, С.Болормаа, Ж.Эрхэсхулан, Д.Батболд, ахлах багш Б.Буянхишиг, ажил олгогчийн төлөөллөөр Монгол Глобал ХХК-ийн захирал Б.Ганбаяр, УДШ-ийн шүүгч Б.Амарбаясгалан нарыг томилсон байна.
- Хөтөлбөрийн дэд хорооны хурлын тэмдэглэл, хэлэлцсэн асуудлыг түүврийн аргаар 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн, 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлтэй танилцахад сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн асуудлыг шуурхай шийдвэрлэсэн байна.
- Хөтөлбөрийн дэд хороо нь Арилжааны эрх зүй хичээлийн хувийн эрх зүйн тэнхимийн сургалтын төлөвлөгөөнд нэмж тусгасан нь олон улсын түвшинд хөрвөх чадвар бүхий эрх зүйч бэлтгэх шинэлэг төдийгүй зоримог алхам болсон байна.
- Хууль зүйн сургуулийн практик сургалтын хөтөлбөрийн удирдлага нь мэдлэгийг хэрэглээ болгох, чадварыг хандлага болгон төлөвшүүлэх шилжилт, төдийгүй бусад сургуулийн хөтөлбөрт жишиг болгох оновчтой тогтолцоо байна. Хууль зүйн сургуулийн бакалаврын хөтөлбөрийг төгсөгчдийн хувьд хууль зүйн практик сургалтын оновчтой хөтөлбөрийн үр дүнд ажил олгогчийн хүсэл зоригт нийцэж, ажлын байрны шаардлага хангасан эрх зүйч бэлтгэгдэж байна.
- МУИС-ийн дүрэм, Багшийн ёс зүйн дүрэм, Хөтөлбөрийн хорооны дүрэм, Сургалтын журам, Захиргааны зөвлөлийн ажиллах журам, Суралцагчийн дадлагын журам, Цахим сургалтын журам, Суралцагчдад сэтгэл зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх журмуудаар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нарийвчилсан харилцааг зохицуулж байна.
- МУИС болон Хууль зүйн сургуулийн стратеги төлөвлөгөө 2016-2024 он урт болон богино хугацааны төлөвлөгөөний дагуу хөтөлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Оюутны санал, гомдлыг бичгээр болон цахимаар хүлээн авч ажилласан ба 2021 онд сургалтын төлбөр төлөх хугацааг сунгуулах хүсэлт 582, үйлдвэрийн дадлага хичээлийн санал асуулга 196, сургуулиас чөлөөлөгдөх 7 хүсэлт ирснийг шийдвэрлэсэн байна.

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн дэд хороо нь Арилжааны эрх зүй хичээлийн хувийн эрх зүйн тэнхимийн сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулсан, мөн либерал артын зарчмаар хичээл сонголтыг хэрэгжүүлж байгаа нь сайн туршлага гэж үзэхээр байна.
- Хууль зүйн сургуулийн практик сургалтын төв нь бусад сургуульд жишиг болохоор олон жилийн туршлага болжээ.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### 4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, оюутан төгсөгчдийн чанарыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан төсөл хөтөлбөрийг Япон улс, БНСУ, БНХАУ, ХБНГУ, АНУ, Англи, Австрали, Тайван зэрэг 21 сургалт эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах гэрээ, дотоодын 5 судалгааны байгууллагатай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулжээ.
- Японы Нагояагийн Их сургуультай 2006 оноос хамтын ажиллагааны гэрээ байгуулж, улмаар Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийг байгуулж, Японы эрх зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэн нийт 8 удаагийн төгсөлтийг хийж, тус сургуулийн төгсөгчдөөс магистрантурт 16, докторантурт 2, нийт 18 төгсөгч гэрээний дагуу суралцсан байна. Мөн, БНСУ-ын Күүкмений Их сургуультай 2011 оноос хамтын ажиллагааны гэрээг байгуулж, 3 төгсөлтийг хийсний зэрэгцээ 5 төгсөгч БНСУ-ын Күүкмений Их сургуулийн магистрын хөтөлбөрт суралцаж байна.
- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь гадаадын болон дотоодын байгууллагуудтай хамтран Олон Улсын эрдэм шинжилгээний хурал 9-г амжилттай зохион байгуулсан баримт, нотолгоотой танилцсан.
- Хууль зүйн сургууль нь УИХ-ын тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хуульчдын холбоо зэрэг байгууллагатай санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажилласан ба Нээлттэй нийгэм форум, Ханс Зайделийн сан, Эмнести Интернейшнл зэрэг олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь сайн талтай.
- Хууль зүйн сургууль нь 2016 оноос хойш 5 улсын их сургуульд зочин багшаар 4 багш ажиллуулсан нь байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд ковид 19 цар тахлын улмаас багш солилцоо зогсонги байдалд орсныг эс тооцвол жил бүр багш солилцооны хөтөлбөр хэрэгжиж, хэвшин тогтсон байна.
- Оюутан солилцооны хөтөлбөрт Японы эрх зүйн хөтөлбөрийн 25 оюутан зуны сургалтын хөтөлбөрт хамрагдсан, БНСУ-ын Күүкмений их сургуульд 45 оюутан, 4 багш зуны сургалтын хөтөлбөрт тус тус хамрагдсан бол Солонгосын талаас мөн 45 оюутан, багшийн хамт МУИС-ийн ХЗС-д ирж, зуны сургалт хөтөлбөртэй танилцжээ.
- Хууль зүйн сургуулийн төгсөгчдийн холбоо 2010 онд байгуулагдсан бөгөөд уг холбооноос сургуульдаа техник тоног төхөөрөмж бэлэглэх, анги тохижуулах, ном сурах бичиг хандивлах зэргээр хамтран ажилладаг ба ХЗС-иас төгсөгчдийн номыг жил бүр уламжлал болгон гаргадаг нь чухал ач холбогдолтой.

#### Онцлог зүйл/Туршлага:

- Японы эрх зүй болон Солонгосын эрх зүйн судлалын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн, төгсөгч нараас Япон болон Солонгос улсад доктор, магистрын зэрэг хамгаалсан.



- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь хамтын ажиллагааны хүрээнд гадаадын их дээд сургуульд багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж хэвшсэн нь онцлох туршлага төдийгүй багшлах боловсон хүчний хувьд гадаад хэлний мэдлэг өндөр байгааг илэрхийлж байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн удирдах зөвлөлөөс баталсан төсвийн хүрээнд ХЗС нь үйл ажиллагаа явуулна. МУИС-ийн Захиргааны зөвлөлд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 05-ны өдрийн дотор танилцуулна. Хууль зүйн сургуулийн захиралд тус бүрэлдэхүүн сургуульд ногдох төсвийг захиран зарцуулах эрхийг шилжүүлсэн тул өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах давуу талтай.
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн нийт орлогын 95 орчим хувь нь эрх зүйн хөтөлбөрөөс төвлөрүүлдэг ба зардлын 48 орчим хувь нь цалингийн зардал, шинээр барих барилгын хөрөнгө оруулалтад сүүлийн 6 жил мөнгө хуримтлуулж байгаа нь сайшаалтай. Мөн, ХЗС-ийн хөтөлбөрийн нийт орлого тогтмол ашигтай гарч байгаа нь сургалтын хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт сайн байгааг илэрхийлж байна.
- Нэг багц цагийн үнэлгээ 111000 төгрөг бөгөөд 2019 оноос хойш өөрчлөгдөөгүй байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

1. Багшийн ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжих төслийн санхүүжилтийг тогтол олгосон нь сайн туршлага юм.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн нийт хичээлийн хөтөлбөр сурталчлах өдөрлөгт байнга хамрагддаг ба нийтийн болон хувийн эрх зүйн тэнхимээс хийсэн ажлын тайланг товхимол болгон жил бүр хэвлэн гаргадаг байна.
- ХЗС-ийн зүгээс Job Fair 2017, бусад байгууллагатай хамтран чадавхжуулах сургалт, танилцах аялал зэрэг олон талт арга хэмжээг зохион явуулдаг.
- Монгол Улсын Их сургуулийн бүрэлдэхүүн 6 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль нь элсэлтийг нэгдсэн байдлаар мэдээлэх цахим хуудас [elselt.num.edu.mn](http://elselt.num.edu.mn) болон бүртгэлийн цахим хуудас [Burtgel.num.edu.mn](http://Burtgel.num.edu.mn) цахим хуудсыг ажиллуулж байна.
- Хууль зүйн сургуулийн хөтөлбөрийн маркетингийн сурталчилгаа нь дотоод, гадаад гэсэн хэлбэрээр явагдаж байгаа бөгөөд дотоод хэлбэрт чиглүүлэх багш,

багш нараас тэнхимд ирүүлсэн саналыг үндэслэн зөвлөгөө өгөх цаг, сургалтын алба зэрэг чиглэлээр явуулж байгаа бол, гадаад маркетингийг Монгол Улсын Боловсролын экспо арга хэмжээнд оролцох хэлбэрээр хэрэгжүүлж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хууль зүйн сургуулийн веб сайт Law.num.edu.mn хаяг нь хэвийн үйл ажиллагаатай ба 6 үндсэн цэсээс гадна багш, элсэгч, оюутан, төгсөгч, ажилтан зэрэг цэсээс оюутан шаардлагатай мэдээллийг бүрэн авах боломжтой байна.
- Хууль зүйн сургуулийн Law.num.edu.mn веб сайт нь англи хэлний сонголттой тул тус сургуулийн мэдээллийг бусад орны судлаачид болон оюутнууд авах боломжийг нээжээ.
- ХЗС-ийн тэнхимүүдээс 2016-2021 оны хооронд нийт хөтөлбөр сурталчлах 18 өдөрлөг зохион байгуулсан нь хөтөлбөрийн ил тод байдалд чухал нөлөө үзүүлсэн байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хууль зүйн сургуулийн Law.num.edu.mn веб сайт нь англи хэлний сонголттой тул тус сургуулийн мэдээллийг бусад орны судлаачид болон оюутнууд авах боломжийг нээжээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

*Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС нь жил бүр оюутан элсүүлэх журмаа шинэчлэн баталдаг бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилийн Оюутан элсүүлэх журмыг 2022 оны 05 сарын 22-ны өдрийн А/166 тоот МУИС-ийн захирлаар тушаалаар баталж, МУИС-ийн элсэлтийн веб сайтад байрлуулан цахим бүртгэлийг эхлүүлэн ажиллаж байна.
- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь суурь хичээл нийгэм судлал /70%/, дагалдах хичээл математик /30%/ бөгөөд тооцоолсон босго онооны хувь 600 байна.
- Хууль зүйн сургуульд элсэхээр бүртгүүлсэн суралцагчдын тоо, элссэн суралцагчдын тоо, элссэн хувь, ЭЕШ-ын онооны дундаж зэргийг сүүлийн 5 жилээр харьцуулан гаргасан байна.

- Элсэлттэй холбоотой дүрэм, журмыг МУИС-ийн цахим хуудас болон элсэгчдэд зориулсан тусгай цахим хуудаст байршуулсан байна.
- МУИС-ийн “Суралцагчийн гарын авлага” –ийг жил бүр шинэчлэн гаргадаг.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэгчдэд ЭЕШ-ын онооны харьцангуй өндөр шаардлага тавьсан нь хөтөлбөрийн зорилгод сайн суралцагч элсэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Сүүлийн 5 жилийн элсэгчдийн ЭЕШ-ын босго оноо дунджаар 684 байна.
- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь сүүлийн 5 жилд Олон улсын болон үндэсний хэмжээний олимпиадад “Нийгмийн тухай мэдлэг” хичээлээр амжилттай оролцсон нийт 14 элсэгчийг урилгаар элсүүлсэн байна.
- МУИС-ийн 2020 оны 05 сарын 08-ны өдрийн А/133 тоот тушаалаар батлагдсан “МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журам”-ын дагуу Хууль зүйн сургуульд БНХАУ, БНСУ, БНАЛАУ, БНСВУ, БНАСУ-ын зэрэг нийт 14 оюутан суралцаж байна.
- Элсэгчдэд зориулсан чиглүүлэх сургалтыг МУИС-ийн оюутан төгсөгчийн хэлтэс жил бүр зохион байгуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Эрх зүйн хөтөлбөрөөр элсэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, бүртгэх, элсүүлэх үйл ажиллагаанд Хууль зүйн сургуулийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Элсэгчдийг ЭЕШ-ын босго онооны шалгуур, шаардлагаас гадна мэргэжлийн онцлогт тохируулсан хандлага, ёс зүйн нэмэлт шалгуур тавих боломжийг судлах
- Элсэгчдийн мэдээлэлд хөдөө орон нутгаас элсэгчдийн мэдээлэлд дүгнэлт хийж үзэх

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагсдад зөвлөн туслах үйл ажиллагааг МУИС-ийн Оюутан төгсөгчийн хэлтэс болон Хууль зүйн сургууль бие даан зохион зохион байгуулдаг.
- Жил бүр оюутанд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг 12 чиглэлээр боловсруулан МУИС-ийн Сургалт, оюутан хариуцсан дэд захирлаар батлуулан, хэрэгжүүлж ажилладаг
- Суралцагчдад зориулан бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн чиглэлүүдийн сургалтыг зохион байгуулдаг.
- Суралцагсдад зөвлөн туслах үйлчилгээ болон судалгаа шинжилгээний үйл ажиллагааг дэмжиж төсөв тусгаж, гүйцэтгэлийг хянаж ажилладаг байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Судалгаа шинжилгээний чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагаа тогтмолжсон бөгөөд энэ чиглэлээр уралдаан тэмцээнд оюутнууд нь тогтмол тэргүүлэх байр суурьтай оролцдог байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагсдад сургуулиас явуулдаг зөвлөн туслах үйлчилгээний болон бусад оюутанд чиглэсэн мэдээлэл зөвлөгөөг шуурхай хүргэдэг, оюутнуудад илүү нээлттэй, чөлөөтэй харилцааг бий болгох
- Суралцагчдад сэтгэл зүйн зөвлөгөө тусалцаа үзүүлдэг болох
- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээний талаар тайлан, тооцоо, бүртгэлтэй болох

#### **Зөвлөмж:**

- Багш бүр өөрийн зааж буй хичээлийн хүрээнд зөвлөх үйлчилгээг тодорхой тооны /мэргэшүүлэх чиглэлийн клуб, дугуйлан/ суралцагчид үзүүлдэг байх нь ирээдүйн ажил мэргэжилд нь чиглүүлэх сайн талтай .
- Сургууль, мэргэжлийн онцлогийг илэрхийлсэн өөрөөр хэлбэл хуульч мэргэжлийн харилцаа, ёс зүйн чиглэлээр тусгайлан анхаарсан зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөө гаргаж ажиллах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хууль зүйн сургуулийн оюутны клуб, дугуйлангууд хичээлийн жилийн эхэнд ажлын төлөвлөгөөгөө боловсруулан сургуулийн захирлаар батлуулж үйл ажиллагаагаа эхлүүлдэг.
- Суралцагчдыг гадаад дотоодын уралдаан тэмцээнд оролцуулах төсөвтэй, батлуулсан төсвийн дагуу үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг байна.
- МУИС-ийн суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журмыг мөрдлөг болгон ажилладаг.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш, оюутны санаачилгаар байгуулагдсан клубүүд нь оюутны илтгэх, мэтгэлцэх ур чадварыг дээшлүүлэх болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, хувь хүний чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.
- Хууль зүйн сургууль нь “Төгсөгч ном”-ыг жил бүр гаргаж ажил олгогчид хүргүүлдэг нь төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэг хөшүүрэг болсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутнуудын нийгмийн идэвх, нийгмийн оролцоо, нийгмийн нөлөөллийг дэмжих чиглэлээр тусгай хөтөлбөр төлөвлөгөө гаргаж ажиллах
- Оюутнуудын сайн дурын ажлыг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллах, улмаар төгсөлтийн баримт бичигт тусгадаг болох

- Тэтгэлэгт хамрагдах хэрэгцээ шаардлагыг бодитойгоор тодорхойлон суралцагчийн
- хамрагдах хүрээг нэмэгдүүлэхэд анхаарах

**Зөвлөмж:**

- МУИС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэх нэгжийн үйл ажиллагааг илүү нээлттэй явуулах, оюутнуудыг суралцангаа хөдөлмөр эрхлэх, цагийн ажил хийх эрхлэх боломжоор хангах, зуучлах, байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн захирлын 2019 оны 11 сарын 14-ны өдрийн А/483 тоот тушаалаар баталсан “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам” –ын дагуу шилжин суралцах асуудлыг шийдвэрлэдэг
- МУИС-ийн захирлын 2015 оны 06 сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар баталсан “МУИС-д сургалтын журам” –ын дагуу суралцагч чөлөө авах, суралцагч үргэлжлүүлэн суралцах, сургуулиас чөлөөлөгдөх хүсэлтийг шийдвэрлэдэг байна.
- Шилжин суралцагчийн багц цаг дүйцүүлэх журмын дагуу Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба, бүртгэлийн алба хийж, МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулдаг.
- МУИС-ийн Хууль зүйн сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд 46, 2019-2020 оны хичээлийн жилд 39, 2020-2021 оны хичээлийн жилд 45 суралцагчийг шилжүүлэн суралцуулсан байна.

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хууль зүйн сургуульд бусад сургуулиас шилжин суралцах хүсэлтэй оюутны тоо жил бүр өсөх хандлагатай байгаа бөгөөд энэ нь сургалтын чанар, багшлах боловсон хүчний чадавх, хүлээн зөвшөөрөгдсөн байдалтай холбоотой.

**Анхаарах асуудал:**

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний байдалд дүгнэлт хийхдээ зөвхөн шилжин ирсэн суралцагчийн бүртгэл, мэдээллээр хязгаарлахгүй тус сургуулиас суралцагч чөлөө авах, , сургуулиас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан суралцагчдын тоо судалгаа, шалтгаанд дүгнэлт хийж, оюутны сэтгэл ханамжийг дээшлүүлж ажиллах.

**Зөвлөмж:**

- Шилжин суралцагчийн хүсэлтийг шийдвэрлэхдээ зөвхөн кредит дүйцүүлэхээр хязгаарлахгүй хандлага, мэргэжлийн ёс зүйн мэдлэгийн шалгуурыг нэмэх

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, БШУЯ-ны холбогдох дүрэм журам, МУИС-д сургалтын журмын дагуу МУИС-ийн захирлын тушаалаар диплом, энгэрийн тэмдэг олгоно.
- Өдрийн ангид суралцагч 150-аас доошгүй багц цаг, орой эчнээ ангид суралцагч 120-оос доошгүй / өмнөх боловсролын багц цагийг тооцон/ багц цаг судалснаар төгсөх болзол хангана.
- Диплом, хавсралтад журмын дагуу МУИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн Захирал, Төгсөлтийн комиссын дарга, Бүрэлдэхүүн сургуулийн захирал гарын үсэг зурна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Солонгосын эрх зүй, Японы эрх зүй зэрэг мэргэшин төгсөж байгаа төгсөгчид 2 орны дипломтой төгсдөг давуу талтай байна.
- МУИС-ийн веб сайтад бүх төгсөгчдийн нэр, дипломын дугаар, бүртгэлийн дугаарыг шалгах боломжтой.

#### **Зөвлөмж:**

- Дипломын цахим баталгаажуулалтыг хувилбарыг нэмэгдүүлэх /блокчэйн технологи/

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

*Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.*

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн багшийг сонгон шалгаруулах, хөгжүүлэх үйл ажиллагаа нь МУИС-ийн хүний нөөцийн бодлоготой холбоотой 20 гаруй дүрэм журмаар зохицуулдаг байна.
- Хууль зүйн сургуулийн нийт багш нарын 50% нь докторын зэрэгтэй.
- Нэг багшид 16 оюутан оногдож байгаа нь багш оюутны зохистой харьцааг хангаж байна.
- Профессор багш нарын сүүлийн 5 жилд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлыг үзүүлэлтийг гол шалгуур болгон хичээлийн жилийн эцэст дараагийн 3 жилд ажиллах багш нарын албан тушаалын зэрэглэлийг МУИС-ийн захирлын тушаалаар тогтоож байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-д багш сонгон шалгаруулалтыг Захиргаа, хүний нөөц хариуцсан нэгж зохион байгуулах ба сонгон шалгаруулалтын зарыг бүрэлдэхүүн сургуулийн захиалгыг үндэслэн 3-аас доошгүй 7 хоногийн өмнө өдөр тутмын сонин болон сургуулийн цахим хуудсаар нээлттэй зарлана.
- Сонгон шалгаруулалтыг “Шинэ багшийн мэргэжлийн шалгалтын комисс” мэргэжлийн болон ярилцлагын шалгалт авч, эрдэм шинжилгээний бүтээлд үнэлгээ өгөх, англи хэлний шалгах авах зэргээр зохион байгуулна.
- Эрдэм шинжилгээний бүтээлээрээ болон тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтнийг сонгон шалгаруулалтгүйгээр дэд профессор, профессорын зэрэглэлд ажиллуулж болно.
- МУИС-ийн Хууль зүйн сургууль нь эрдмийн зэрэгтэй багшийн нийт багшид эзлэх хувийг 70% болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

### **Анхаарах асуудал:**

- “МУИС-ийн профессор багш ажиллуулах журам”-д заасан профессор цол олгох болзлын шалгаруулалтын үнэлгээг нийгэм ухааны салбарт тохирсон уян хатан байдлаар зохицуулах боломжийг судлах
- Тэнхимийн туслах багш нарын тоог нэмэгдүүлэх замаар багш нарын ажлын ачааллыг бууруулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны хийх цагийг нэмэгдүүлэх

### **Зөвлөмж:**

- Багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан олгох шагнал, урамшууллын төрлийг нэмэгдүүлэх, багш нарыг урамшуулах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр 2019-2024 бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.
- МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь МУИС-ийн нийт багш нарын багш хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилладаг байна.
- МУИС нь багш нарыг хөгжүүлэх урт богино, дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ажиллаж ирсэн бөгөөд эдийн засгийн зохих дэмжлэг үзүүлж ажилладаг.
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарын хүрээнд Мэргэжлийн их семинар, Олон улсын болон сургуулийн эрдэм шинжилгээний хурал, багш солилцооны хөтөлбөр, ахисан түвшний сургалт, докторын дараах сургалтын хөтөлбөр, хэлний боловсролыг дээшлүүлэх сургалт зэрэг сургалт, арга хэмжээнүүдэд бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлэн ажиллаж ирсэн байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн хууль зүйн сургуулийн багш нарыг эрх зүйн тодорхой чиглэл, хамтын ажиллагааны хүрээнд, багшийн мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор зочин профессорын сургалтыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд сүүлийн 5 жилд 10 зочин профессорын сургалт зохион байгуулсан байна.
- Сүүлийн 5 жилд давхардсан тоогоор гадаадын 31 улс оронд Хууль зүйн сургуулийн 100 гаруй багш сургалт, судалгааны ажилд оролцсон байна.

#### **Анхаарах асуудал:**

- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш хөгжлийн тусгай хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох
- Багшийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөнд багш нарын саналыг авч, хөтөлбөрийн багш нарын онцлогт сургалт, хөтөлбөрүүдийг зохион байгуулах
- Багшийг хөгжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх, жилийн төсөвт тодорхой төлөвлөлтөөр тусгах, гүйцэтгэлийг багш нартаа танилцуулдаг болох

#### **Зөвлөмж:**

- Эрх зүйн хөтөлбөрийн багш нарын А цагийн ачааллыг бууруулах арга замыг судлах
- Багш хөгжлийн хувийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах
- Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан багшийг хөгжүүлэх тодорхой сургалтуудыг төлөвлөдөг болох

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- МУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлын чанарыг сайжруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх бие даасан дүрэм журмууд үйлчилж байна.
- “МУИС-ийн судалгааны санхүүжилтийн журам”-ыг МУИС-ийн захирлын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/349 тоот тушаалаар шинэчлэн хэрэгжүүлж ажиллаж байна.
- МУИС нь судалгааны суурь зардал, залуу судлаачдын багийн тэтгэлэг, зочин судлаач, докторын дараах судалгааны тэтгэлэг, өндөр түвшний судалгааны төсөл, өртөг хуваалцах хамтарсан төсөл, инновацын төслүүдийг санхүүжүүлж байна.
- “МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам”-ыг МУИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 20-ны өдрийн А/13 тоот тушаалаар батлан ажиллаж байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- МУИС-ийн багш, ажилтны хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийн журам”-д Бүрэлдэхүүн сургууль нь бакалаврын сургалтын төлбөрийн орлогын 2 хувийг багшийн судалгааны цогц чадамж, сургалтын цогц чадамж, ажилтны эрүүл мэндийн үйлчилгээ, цогц чадамжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд зарцуулахаар журамлажээ.



- Профессор, багшид олгох судалгааны санхүүжилтийн хэмжээг жил бүр шинэчлэн баталж мөрдөж бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар профессорын зэрэглэлд ажиллаж байгаа доктор багшид 2,0 сая төгрөг хүртэл, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа доктор багшид 1,0 сая төгрөг хүртэл төгрөг олгож байна.
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нараас 2018-2019 оны хичээлийн жилд 11 багш, 2019-2020 оны хичээлийн жилд 7 багш, 2020-2021 оны хичээлийн жилд 15 багш, сүүлийн 3 жил нийт 43 багш судалгааны санхүүжилт авсан 2018-2019 оны хичээлийн жилд 13 багш, 2020-2021 оны хичээлийн жилд 18 багш, сүүлийн 3 жилд 31 багш дотоод төслийн санхүүжилт тус тус авсан байна.
- Хууль зүйн сургуулийн нийт төсөвт эрдэм шинжилгээний ажлын зардал 2018-2019 оны хичээлийн жилд 7%, 2019-2020 оны хичээлийн жилд 1%, 2020-2021 оны хичээлийн жилд 2% байна.
- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нар нь захиалгат болон төсөл хөтөлбөр гүйцэтгэх замаар судалгааны ажлын дэмжлэгүүдийн авч байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багш нарын судалгааны ажлыг олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлэх, гадаадын болон олон улсын судалгааны байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

#### **Зөвлөмж:**

- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарын гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ судалгааны ажил, төсөл, хөтөлбөрүүдийн цахим мэдээллийн сан үүсгэх

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багшийн ажлын гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомж болон МУИС-ийн профессор багш ажиллуулах журамд заасны дагуу багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.
- Багш нарын жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг үнэлж урамшуулалт цалин олгодог бөгөөд урамшуулалт цалин нь үндсэн цалингийн 40% хүртэл байдаг байна.
- Жилийн ажлыг гүйцэтгэлийн тайланг багш, ажилтнуудаар бичүүлж бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг үнэлгээг олгодог. Тайланг 1. Үндсэн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 40 оноо, 2. Тусгай ажлын гүйцэтгэл 20 оноо, 3. Хамт олны үнэлгээ 10 оноо, 4. Оюутны үнэлгээ 10 оноо, 5. Удирдлагын үнэлгээ 20 оноо гэсэн 5 үзүүлэлтийн дагуу үнэлдэг байна.
- МУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн хөгжилд хувь нэмэр оруулсан, хамт олноо бүр талаар манлайлан ажилласан байдал, ёс зүй зэргийг харгалзан “МУИС-ийн шагнал, урамшуулал олгох нийтлэг журам”-ын дагуу багш нараа шагнаж урамшуулах буюу Монгол улсын Засгийн газар, Төрийн одон медалиудаар шагнуулахаар зохих журмын дагуу уламжлан шийдвэрлүүлдэг

- МУИС-ийн багш нар МУИС-д үйлчилж буй дүрэм журмын хүрээнд аттестатчиллын шалгалтад ордог. Энэ нь багш тухайн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж байгааг тогтоход оршино.
- Багшийн ажлыг үнэлэх бас нэгэн үзүүлэлт бол профессор, дэд профессор цолны болзол хангах явдал юм.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын мэдээллийн системээр дамжуулан жилд 2 удаа оюутнуудаас багшийн талаар, сургалтын орчин, хичээлийн талаар гэсэн 3 хэсэг бүхий сэтгэл ханамжийн судалгаа авч энэ нь багшийн ажлыг үнэлэх нэг хэсэг болж хэвшсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын мэдээллийн системээр авч буй санал асуулгын асуулгын боловсруулалтыг тухайн хичээлийн жил, улирлын онцлогт тохируулан шинэчлэлт, өөрчлөлтийг хийдэг байх.

#### **Зөвлөмж:**

- Багшийн талаар болон хичээлийн талаар авсан оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн бодит байдалд дүгнэлт хийх механизмыг бүрдүүлэх
- Оюутнуудаас авсан судалгааны үр дүнг хөтөлбөр, тэнхмээр нь болон жил улирлаар нь харьцуулан гаргаж үр дүнг тооцох, багшийн судалгааг улирал тутам багшид танилцуулж үр дүнгээ тооцох боломжоор хангах

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

*Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.*

### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2017 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба байгуулан ажиллуулж хөтөлбөрт байнгын үнэлгээ хийх, сайжруулалтын заавар чиглэл өгөхөөс гадна дотоод болон гадаад олон улсын магадлан итгэмжлэлд ороход нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаж байна.
- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын төлөвлөгөө гарган МУИС-ийн хөтөлбөрийн дэд хороо болон тэнхимтэй хамтран ажиллаж байна.
- Хөтөлбөрт оюутан, төгсөгч, ажил олгогсдоос судалгаа авч хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоог хангаж ажиллаж байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс нь жил бүр гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргаж гүйцэтгэлийг хөтөлбөрт оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлж ажилладаг.
- Улирал бүр оюутнуудаас хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой санал асуулга авч үр дүнд үндэслэн тэнхим, багш нарынхаа ажлыг үнэлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтсээс хөтөлбөрийн хэрэгжилтэд нь хөндлөнгийн үнэлгээ хийж, сайжруулах талаар зөвлөмж чиглэл өгдөг байх

#### **Зөвлөмж:**

- Төгсөгч болон ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авах хугацааг тодорхой болгох, тогтмолжуулах /Судалгааг ямар хугацаанд авдаг эсэх болон судалгаануудын он тодорхойгүй байсан/
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд сургууль, тэнхим, багш өөрийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх

#### **Шаардлага:**

- Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс Хууль зүйн сургуулийн дотоод чанарын үнэлгээ, баталгаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн чиглүүлж ажилладаг байх
- Чанарын баталгаажуулалтыг зохион байгуулах, ямар схем, арга зүйн дагуу үр дүнг хэрхэн үнэлэх, тасралтгүй сайжруулалтын циклийг хэрхэн хийх механизмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнг сургууль, тэнхимийн хурлаар хэлэлцэж, хөтөлбөрийн сайжруулалтад ашигладаг, ахиц үр дүнг үнэлдэг байх

## Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

### 7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

#### Илрэл нотолгоо:

- Эрх зүйн хөтөлбөрөөр төгсөгч болон ажил олгогчдоос хөтөлбөрийн үр дүнгийн талаар судалгаа авсан.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа гаргасан.
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын үр дүнгээр төгсөгчдийн чанарыг үнэлэх судалгааг хийсэн.
- Төгсөгчдийг ажлын байранд зуучлах ажлуудын тодорхой хэлбэрүүдээр хэрэгжүүлж хэвшсэн.

#### Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчид болон төгсөгчидтэй хийх ярилцлагын үеэр тус сургуулийн төгсөгчид сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангаж байгаа талаар илэрхийлж байсан. Ялангуяа онолын мэдлэг болон мэргэжлийн ур чадварыг онцлон хэлж байсан болно.

#### Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байрны судалгаа, карьер өсөлтийн судалгааг жил бүр шинэчлэн гаргаж хэвшүүлэх
- Мэргэжлийн гадаад хэлний хичээлийн чанар, үр дүнд анхаарах

#### Зөвлөмж:

- Төгсөгчдийн давтан сургалт болон ажлын байран дахь сургалтын зохион байгуулах
- Хөтөлбөрийн шинэчлэлд мэдээллийн технологийн хэрэглээ буюу орчин үеийн сургалтын шинэ арга, арга зүй нэтрүүлэх, зохион байгуулалтын тодорхой ажлуудыг үе шаттай хийх

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### 7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- МУИС нь БМИУЗ-ийн байгууллагын магадлан итгэмжлэлд 3 удаа орсон.
- Хууль зүйн сургуулийн Эрх зүйн хөтөлбөр нь 2014 онд хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон.

#### Онцлог зүйл/Туршлага:

- Япон улсын Ногаягийн их сургуультай хамтарсан японы эрх зүй, БНСУ-ын Күүкминий их сургуультай хамтарсан солонгосын эрх зүй анги тус тус хичээллэж 2 улсын дипломтой төгсөж байна.
- Хууль зүйн сургуулийн оюутнууд Гадаад болон дотоодын мэргэжлийн уралдаан тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож, эхний байруудад шалгардаг.
- Төгсөгчдийн Хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцсэн хувь 55%-48% байна.

### **Зөвлөмж:**

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэлийн холбоо мэргэжлийн зөвлөлөөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх боломжийг судлах

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

### **ДҮГНЭЛТ**

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1		7.1
<b>ДҮГНЭЛТ</b>		<b>Бүрэн хангасан</b>			

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Оролцогч болон сонирхогч талуудыг тодорхойлох болон тэдгээрийн хэрэгцээ, хүлээлтийн судалгааг хийх</li> <li>- МУИС-ийн холбогдох алба нэгжээс зохион байгуулж явуулсан, ХЗС-аас авсан аливаа судалгааны үр дүнг хөтөлбөрийн сайжруулалт хийхэд тогтмол ашиглах</li> <li>- Хөтөлбөрийг үндэсний мэргэшлийн хүрээ ба хөтөлбөрийн нийцлийг авч үзэж дүн шинжилгээ хийсэн байх.</li> <li>- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилгод судалгаа хийж үйл ажиллагаандаа ашиглах.</li> <li>- “Хөтөлбөрийн зорилго нь хичээлийн хөтөлбөрт тусгагдсан эсэх талаар үнэлгээ хийж, цаашид сайжруулахад төвөгтэй байх” гэсэн өөрийн үнэлгээний багаас тодорхойлсон эрсдэлийг сааруулах, бууруулах, арилгах талаар зохих ажлыг зохион байгуулах.</li> <li>- Сонирхогч, оролцогч талуудын оролцоог хангах, тэдгээрийн санал зөвлөмжийг үйл ажиллагаагаа болон хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусган ажиллах, тэдгээрийг баримтжуулж хэвших.</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- -Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа эсэх талаар судалж дүн шинжилгээ хийх</li> <li>- -Багш сонголтын хувийг нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлэх. МУИС-ийн сургалтын журам болон стратегийн баримт бичигт оюутан багшийн зохистой харьцааг 15:1 байхаар тогтоосныг баримтлах.</li> <li>- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа эсэх талаар судалгаа, дүн шинжилгээ хийх.</li> <li>- Суралцагчийн “хандлага”-ыг хэрхэн үнэлэх талаар хөтөлбөрт тусгасан хүрэх үр дүнтэй уялдуулан тогтоох.</li> <li>- Оюутны үнэлгээ, амжилт ахиц зэрэг статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх процессыг тодорхойлж зохих зохицуулалт хийх.</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөсөн сургалтын орчин нөхцөлийг хангасан сургуулийн барилгыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.</li> </ul>

<p>Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Элсэгчдийг ЭЕШ-ын босго онооны шалгуур, шаардлагаас гадна мэргэжлийн онцлогт тохируулсан хандлага, ёс зүйн нэмэлт шалгуур тавих боломжийг судлах</li> <li>- Элсэгчдийн мэдээлэлд хөдөө орон нутгаас элсэгчдийн мэдээлэлд дүгнэлт хийж үзэх</li> <li>- Багш бүр өөрийн зааж буй хичээлийн хүрээнд зөвлөх үйлчилгээг тодорхой тооны /мэргэшүүлэх чиглэлийн клуб, дугуйлан/ суралцагчид үзүүлдэг байх нь ирээдүйн ажил мэргэжилд нь чиглүүлэх сайн талтай .</li> <li>- Сургууль, мэргэжлийн онцлогийг илэрхийлсэн өөрөөр хэлбэл хуульч мэргэжлийн харилцаа, ёс зүйн чиглэлээр тусгайлан анхаарсан зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөө гаргаж ажиллах</li> <li>- Шилжин суралцагчийн хүсэлтийг шийдвэрлэхдээ зөвхөн кредит дүйцүүлэхээр хязгаарлахгүй хандлага, мэргэжлийн ёс зүйн мэдлэгийн шалгуурыг нэмэх</li> <li>- Дипломын цахим баталгаажуулалтыг хувилбарыг нэмэгдүүлэх /блокчэйн технологи/</li> </ul>
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан олгох шагнал, урамшууллын төрлийг нэмэгдүүлэх, багш нарыг урамшуулах</li> <li>- Эрх зүйн хөтөлбөрийн багш нарын А цагийн ачааллыг бууруулах арга замыг судлах</li> <li>- Багш хөгжлийн хувийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах</li> <li>- Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд тулгуурлан багшийг хөгжүүлэх тодорхой сургалтуудыг төлөвлөдөг болох</li> <li>- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш нарын гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ судалгааны ажил, төсөл, хөтөлбөрүүдийн цахим мэдээллийн сан үүсгэх</li> <li>- Багшийн талаар болон хичээлийн талаар авсан оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн бодит байдалд дүгнэлт хийх механизмыг бүрдүүлэх</li> <li>- Оюутнуудаас авсан судалгааны үр дүнг хөтөлбөр, тэнхмээр нь болон жил улирлаар нь харьцуулан гаргаж үр дүнг тооцох, багшийн судалгааг улирал тутам багшид танилцуулж үр дүнгээ тооцох боломжоор хангах</li> </ul>
<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төгсөгч болон ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авах хугацааг тодорхой болгох, тогтмолжуулах /Судалгааг ямар хугацаанд авдаг эсэх болон судалгаануудын он тодорхойгүй байсан/</li> <li>- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнг сургууль, тэнхимийн хурлаар хэлэлцэж, хөтөлбөрийн сайжруулалтад ашигладаг, ахиц үр дүнг үнэлдэг байх</li> <li>- Хөтөлбөрийн хэрэгжилтэд сургууль, тэнхим, багш өөрийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх</li> <li>- Төгсөгчдийн давтан сургалт болон ажлын байран дахь сургалтын зохион байгуулах</li> <li>- Хөтөлбөрийн шинэчлэлд мэдээллийн технологийн хэрэглээ буюу орчин үеийн сургалтын шинэ арга, арга зүй нэтрүүлэх, зохион байгуулалтын тодорхой ажлуудыг үе шаттай хийх</li> </ul>

	- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн магадлан итгэмжлэлийн холбоо мэргэжлийн зөвлөлөөр хөндлөнгийн үнэлгээ хийлгэх боломжийг судлах
Шалгуур	Шаардлага
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<p>7.1 - Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс Хууль зүйн сургуулийн дотоод чанарын үнэлгээ, баталгаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн чиглүүлж ажилладаг байх</p> <p>- Чанарын баталгаажуулалтыг зохион байгуулах, ямар схем, арга зүйн дагуу үр дүнг хэрхэн үнэлэх, тасралтгүй сайжруулалтын циклийг хэрхэн хийх механизмыг бүрэн хэрэгжүүлж ажиллах</p> <p>- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүнг сургууль, тэнхимийн хурлаар хэлэлцэж, хөтөлбөрийн сайжруулалтад ашигладаг, ахиц үр дүнг үнэлдэг байх</p>

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “ЭРХ ЗҮЙ” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн ЭРХ ЗҮЙН чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:

Д.Эрдэнэбаатар

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

С.Энхбаяр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:

Г.Туяа



## V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

### I. Багш нартай хийх уулзалт

№	Овог нэрс	Албан тушаал	Үндсэн мэргэжил	Заадаг хичээл	Утас
1	Д.Баярсайхан	Профессор	Эрх зүйч, хуульч	Эрх зүй онол, эрүүгийн процессын эрх зүй	99186435
2	Х.Сэлэнгэ	Зөвлөх профессор	Эрх зүйч, хуульч	Ромын эрх зүй, эрх зүйн философи	99055109
3	О.Мөнхсайхан	Профессор	Эрх зүйч	Хүний эрх /ахисан түвшин/	99905591
4	Э.Байгаль	Дэд профессор	Эрх зүйч, хуульч	Олон улсын хувийн эрх зүй, Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй	93110307
5	С.Болормаа	Дэд профессор, Практик сургалтын төвийн эрхлэгч	Эрх зүйч, хуульч	Хөдөлмөрийн эрх зүй	99097430
6	Т.Золбоо	Багш	Эрх зүйч, хуульч	Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, эрүүгийн эрх зүйн тусгай анги	99900988
7	Б.Буянхишиг	Ахлах багш	Эрх зүйч, хуульч	Иргэний эрх зүйн ерөнхий анги, иргэний эрх зүйн тусгай анги, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй	91996470
8	Г.Давааням	Ахлах багш	Эрх зүйч, хуульч	Арилжааны эрх зүй, арилжааны гэрээний эрх зүй, компанийн эрх зүй	91449191
9	А.Солонго	Багш	Эрх зүйч, хуульч	Эрх зүйн онол	99100381
10	Э.Туулайхүү	Багш	Эрх зүйч, хуульч	Олон улсын нийтийн эрх зүй	80449003
11	Р.Пүрэвбаатар	Багш	Эрх зүйч, хуульч	Гэм хорын эрх зүй, иргэний эрх зүйн ерөнхий анги, иргэний эрх зүйн тусгай анги, арилжааны эрх зүй	95115454
12	Л.Банзрагч	Багш	Эрх зүйч, хуульч	Арилжааны гэрээний эрх зүй, Компанийн эрх зүй, Гэрээний эрх зүй, Иргэний эрх зүйн ерөнхий анги	99089663

II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал	Утас
1	О.Анхбаяр	3	Улаанбаатар хот	90707775
2	Б.Уранцэцэг	5	Улаанбаатар хот	95932266
3	Б.Оюундэлгэр	5	Улаанбаатар хот	89373768
4	Т.Мөнхбат	3	Улаанбаатар хот	88640502
5	Д.Гантуяа	3	Улаанбаатар хот	99056590
6	Н.Жавхлан	3	Улаанбаатар хот	80565054
7	М.Долгорсүрэн	3	Улаанбаатар хот	96208120
8	Ц.Батжаргал	3	Улаанбаатар хот	91850727
9	С.Билэгт-Очир	3	Улаанбаатар хот	95289966
10	У.Есүдэ	3	Улаанбаатар хот	95276688
11	Б.Намуун-Эрдэнэ	3	Улаанбаатар хот	99704442
12	Б.Отгонжаргал	3	Улаанбаатар хот	99381498
13	Б.Гэрэлт-Од	4	Улаанбаатар хот	88275540
14	Э.Эрдэнэ-Очир	4	Улаанбаатар хот	95980998
15	А.Гэрэлцогт	4	Улаанбаатар хот	88526504
16	Д.Хулан	4	Улаанбаатар хот	95545776
17	Э.Халиун	4	Улаанбаатар хот	95260676
18	М.Онон	4	Улаанбаатар хот	80668977
19	М.Номунзул	4	Улаанбаатар хот	88813056
20	Л.Нандинцэцэг	4	Улаанбаатар хот	95936475

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Нэрс	Байгууллага, албан тушаал	Утас
1	н.Батхүү	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар, дарга	88115930
2	н.Болор	БГ, ХУД-ийн ИХАШШ, Тамгын дарга	91113301
3	н.Дашдондов	СХД-ийн ЭХАШШ-ийн Ерөнхий шүүгч	88113478
4	И.Мөнхзалгамж	ХУД-ийн Прокурорын газар, Тамгын хэлтсийн дарга	99098181
5	н.Мөнхбат	УЕПГ, сургалт судалгаа хариуцсан прокурор	99823952
6	н.Болорчимэг	Монгол Өмгөөлөгч ХХН, Партнер, Ахлах өмгөөлөгч	89093996
7	Б.Мэргэн	“Веритас партнерс” ХХН, Өмгөөлөгч	99125557
8	Б.Наранцэцэг	Фиделитас партнерс, Захирал	99785671

9	н.Алтанхуяг	Монголын төмөр замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Хуулийн зөвлөх	86110610
10	н.Эрдэм-Ундрах	Хууль зүйн үндэсний хүрээлэн, Захирал	99095282
11	н.Баттулга	НЗДТГ, Хуулийн хэлтэст	99090290
12	н.Солонго	Таванбогд ХХК, Ахлах хуульч	99083943
13	н.Төрбат	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шинжээч	88007383

IV. Төгсөгсөгчидтэй хийх уулзалт

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Төгссөн он /2015-2022/	Анги	Утас
1.	Б.Пүрэвсүрэн	Глоб Интэрнэйшнл ТББ, хуульч	2015 он	Эрх зүй	99128391
2.	Т.Мөнхтуяа	Legal link CBA, хуульч	2016 он	Эрх зүй	80106988
3.	Б.Анхбаяр	TESO групп, хуулийн хэлтсийн дарга	2016 он	Японы эрх зүй	99029407
4.	З.Хүслэн	Багануур дүүргийн прокурорын газар, прокурор	2017 он	Эрх зүй	88045090
5.	А.Түвшинтөгс	Өмгөөллийн Номун түншлэл ХХК-ийн гүйцэтгэх захирал	2017 он	Эрх зүй	99026022
6.	О.Жаргалтхаан	Таван богд капитал ББСБ, хуульч	2017 он	Эрх зүй	99108860
7.	Г.Ундрал	Хархорин сум дах Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, шүүгчийн туслах	2017 он	Японы эрх зүй	99411664
8.	Б.Өсөхбар	Melville Erdenedalai ХХН, өмгөөлөгч	2018 он	Олон Улсын эрх зүй	99059213
9.	Э.Цэлмэг	Пэнн Стэйт Сургуулийн эрх зүйн магистрийн хөтөлбөр	2018 он	Олон Улсын эрх зүй	АНУ-д байгаа
10.	М.Маргад-Эрдэнэ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, хуульч	2018 он	Эрх зүй	99446446

11.	С.Арна	Монгол даатгал ХХК, хуульч	2018 он	Японы эрх зүй	95093391
12.	Т.Батсүмбэр- Уул	Legal network ХХН, өмгөөлөгч	2019 он	Эрх зүй	88053725
13.	У.Азжаргал	Хууль зүйн үндэсний хүрээлэн, мэргэжилтэн	2019 он	Эрх зүй	99333203
14.	Г.Номунгэрэл	Өмгөөллийн эрх зүйн зөвлөх төв	2020 он	Эрх зүй	80180535
15.	М.Цэрэнбат	Цогт энд Нандин ХХН, Хуульч	2021 он	Эрх зүй	88106411
16.	Н.Мөнхсүлд	Хасбанк ХХК, хуульч	2021 он	Эрх зүй	90305040
17.	Я.Мөнхтулга	ХанЛекс партнерс ХХН, туслах хуульч	2021 он	Эрх зүй	80894994
18.	А.Номин- Эрдэнэ	Өмгөөллийн Өү Ти Эс адвокатс- өмгөөлөгчийн туслах	2021 он	Эрх зүй	91550330
19.	Г.Энэрэл	Шинэ төгсөгч	2022 он	Олон Улсын эрх зүй	91893787
20.	Э.Энхчулуун	Alison and Kate partners ХХН, өмгөөлөгчийн туслах	2022 он	Японы эрх зүй	95257768
21.	Б.Мөнх-Очир	Эрдэнэс тавантолгой ТӨХК, хуульч /туршилтын хугацаа/	2022 он	Эрх зүй	88701137
22.	Б.Жавзмаа	Шинэ төгсөгч	2022 он	Эрх зүй	88221527

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ**

14201 Улаанбаатар хот-4ба ш/х-324, Сүхбаатар дүүрэг,  
Нэгдсэн Үндэстний гудамж 17, Утас/Факс: (976-11) 32-96-80,  
E-mail: law@num.edu.mn, http://law.num.edu.mn

2022. 08. 23 № 11/151

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДЭД ДАРГА, АЖЛЫН  
АЛБАНЫ ЗАХИРАЛ О.ЯНЖМАА  
ТАНАА

**Албан бичиг хүргүүлэх тухай**

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн D421101 индекс дугаартай "Эрх зүй" бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрүүдэд сургууль дээр ажилласан "Шинжээчийн үнэлгээний тайлан"-г хүлээн авч, ажлын хэсгийн гишүүдийн хамтаар бүрэн танилцлаа.

Эрх зүйн хөтөлбөрийн онцлогтой холбоотойгоор үнэлгээний тайланд хичээлийг сонгон судлах боломжийг бий болгосон, клиник сургалтыг мэргэжлийн бөгөөд практик туршлага бүхий багшийн удирдлага дор явуулдаг сайн туршлагыг онцлон тэмдэглэжээ.

Үнэлгээний тайланд дурдсан нэгдсэн зөвлөмжийг хүлээн авч, цаашид "Эрх зүй" бакалаврын хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр бүрэлдэхүүн сургууль төдийгүй МУИС-ийн нэгдсэн удирдлагуудтай санал солилцож, хамтран ажиллах болно.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ  Б.АМАРСАНАА

